

# БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ТҮГШИЛТИЙГ БУУРУУЛАХ СЭТГЭЛ ЗҮЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

СЭТГЭЛ ЗҮЙЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

---

I



*Энэхүү сэтгэл зүйн цогц үйлчилгээний хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын Цахим-Ази хөгжил түншлэлийн сангийн санхүүжилтээр Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй “Орон нутгийн оролцоонд тулгуурлан КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах нь” төслийн хүрээнд боловсруулав.*



ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ



From  
the People of Japan

*Хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бус нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн сэтгэл зүйч, мэргэжилтнүүдэд зориулан хэвлэв.*

#### **БОЛОВСРУУЛСАН:**

**Д.ЦОГЗОЛМАА**, Сэтгэл судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор

**Ц.ДАВААСҮРЭН**, Гүүд Нэйборс ОУТББ-ын Хөтөлбөр Зохицуулалтын Хэлтэс,  
Төслийн мэргэжилтэн, сэтгэл зүйч

#### **ХЯНАСАН:**

**А БҮРЭНЖАРГАЛ**, Гүүд Нэйборс ОУТББ-ын Ахлах менежер

**Г.НЯМБАЯР**, Гүүд Нэйборс ОУТББ-ын Хөтөлбөр Зохицуулалтын Хэлтсийн менежер

**Б.ЭРДЭНЭСУВД**, Гүүд Нэйборс ОУТББ-ын Төсөл хөгжүүлэлтийн албаны ахлах мэргэжилтэн

ISBN: 978-99978-968-9-6

© Энэхүү сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөр нь Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын оюуны өмч тул зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн олшруулах, нийтлэх, нэвтрүүлэх, цахим системд оруулах болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

## АГУУЛГА

---

### I. ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

### II. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

### III. ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхээс өмнө анхаарах зүйлс, бэлтгэл ажил

Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад анхаарах, бэлтгэх зүйлс

### IV. ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ, ЗААВАРЧИЛГАА

Хөтөлбөрт шаардагдах аргачлал, хэрэглэгдэхүүн

Нэг. Аюулгүй байдлын мэдрэмж бий болгох, тааламжгүй мэдрэмжийг бууруулах уулзалт

Хоёр. Сэтгэл зүйн үнэлгээ хийх уулзалт

Гурав. Мэдрэмж гадагшлуулах уулзалт

Дөрөв. Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн тухай ярилцах уулзалт

### V. СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮЕД ТУЛГАРЧ БОЛОХ БЭРХШЭЭЛ, ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИ

### VI. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Уулзалтын тэмдэглэлийн хуудас

Хавсралт 2. Сэтгэл зүйн үнэлгээний хуудас (Үйлчлүүлэгчид зориулсан)

Хавсралт 3. Сэтгэл зүйн үнэлгээний хуудас (Сэтгэл зүйчид зориулсан)

Хавсралт 4. Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ оноогоор илэрхийлэх шугам

Хавсралт 5. Хөтөлбөрийг дагалдах хэрэглэгдэхүүний танилцуулга

### VII. НОМ ЗҮЙ

## ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

4

Түр хамгаалах байранд аюулгүй байдал нь эрсдэлд учирсан, хамгаалан байршуулах шаардлагатай хүчирхийллийн даван туулагч эмэгтэйчүүд, хүүхдүүдийг шаардлагатай хугацаагаар байрлуулдаг. Хамгаалах байраар үйлчлүүлж буй даван туулагчдын хувьд сэтгэл хөдлөл тогтворгүй, айдас түгшүүрт автсан, аюулгүй байдлын мэдрэмж алдагдсан, цочролын дараах сэтгэцийн гэмтэлд өртсөн байх нь түгээмэл тохиолддог. Иймээс хамгаалах байрны сэтгэл зүйн үйлчилгээний онцлог, гол шаардлага нь богино хугацаанд тайвшруулж, аюулгүй байдлын мэдрэмжийг нэмэгдүүлж, сэтгэл түгшилтийг багасгах юм.

Сэтгэл түгшилтийг багасгахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийг түр хамгаалах байранд ажиллаж буй сэтгэл зүйчдийн ажлын онцлог нөхцөлд тохируулан уулзалт тус бүрд сэтгэл зүйч сэлгэн ажиллах боломжтой байдлаар анхлан байрлаж буй, хүчирхийллийн даван туулагч бага насны хүүхдийн сэтгэл түгшилтийг бууруулахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээнд зориулж боловсруулав.

Бага насны хүүхдийн (3-10 насны) сэтгэл түгшилтийг багасгахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийг хүчирхийллийн хохирогч/даван туулагчийн аюулгүй байдлыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг Нэг Цэгийн Үйлчилгээний төв, Хамгаалах байрны сэтгэл зүйн үйлчилгээнд арга зүйн удирдамж, аргачлал байдлаар ашиглана.

### ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИУЛАЛТ, ҮЕ ШАТ

Зөвлөгөөний хөтөлбөрийн зорилго нь Түр Хамгаалах байр, НЦҮТ-д байрлаж буй хүчирхийллийн даван туулагч, гэрч 3-10 насны хүүхдийн сэтгэл түгшилтийг бууруулахад хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон оношилгооны арга, заслын аргачлалыг ашиглаж сэтгэл зүйн үнэлгээ хийх замаар сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ.



#### ХЭНД ЗОРИУЛАГДСАН:

Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн даван туулагч 3-10 насны хүүхдэд



#### ХААНА ХЭРЭГЖИХ:

НЦҮТ, Түр хамгаалах байр



#### УУЛЗАЛТЫН ТОО, ҮЕ ШАТ:

4 удаагийн уулзалт



**СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ДАВТАМЖ,  
УУЛЗАЛТЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:**

4 удаагийн уулзалт, уулзалт бүр 40 хүртэл минут



**ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ НИЙТ  
ХУГАЦАА:**

21-28 хоног



**УУЛЗАЛТ БУЮУ ҮЕ ШАТ  
ХООРОНДЫН ХУГАЦАА:**

4 удаагийн уулзалт



**АШИГЛАХ МАТЕРИАЛ:**

Зөвлөгөөний хөтөлбөр, түүний хавсралт болон дагалдах багц хэрэглэгдэхүүн



Жич: Кодыг мэргэжилтнүүд хоорондоо мэдээлэл солилцох зорилгоор хэрэглэж болно. Мөн кодыг Уулзалтын тэмдэглэлийн хуудаст /Хавсралт 1/ тэмдэглэнэ.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

6

Хүчирхийллийн даван туулагчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний онцлог нь богино хугацаанд сэтгэл түгшилтийг багасгах, тайвшруулах, сэтгэл зүйн үнэлгээ хийх, таагүй мэдрэмжийг гадагшлуулах, цаашид ийм нөхцөл байдал давтагдвал өөрийн болон үр хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар мэдээлэлтэй болгоход чиглэнэ.

### ХҮЧИРХИЙЛЛИЙН ДАВАН ТУУЛАГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХУВЬД



#### **СЭТГЭЛ ХӨДЛӨЛ ТАЛААС:**

айдас, түгшилт, тайван бус байдал, цочирдох, удаан хугацаанд энэхүү нөхцөл байдал үргэлжилбэл сэтгэл гутралын шинжүүд



#### **БИЕ МАХБОД ТАЛААС:**

зүрх дэлсэх, даралт тогтворгүйтэх, булчин чангарах, түүнчлэн стресст үзүүлэх бие махбодын бусад хариу урвалын шинжүүд



#### **ЗАН ҮЙЛИЙН ТАЛААС:**

Тогтворгүй, харилцаанд нээлттэй бус байх, идэвх буурах, үйл ажиллагаанд оролцох сонирхол буурах зэрэг шинжүүд нийтлэг илрэхээс гадна хувь хүний онцлог бүхий бусад шинжүүд илэрч болно.

Хүчирхийллийн даван туулагч хүүхдийн хувьд насандаа тохирохгүй зан ааш гаргах, дуугаа хураах, эсвэл үгүйсгэл өндөртэй байх, тайван бус байх, сэтгэл түгшилт, анхаарал тогтворгүй байх, харилцаанд идэвх сонирхол буурах, өөртөө итгэлгүй байх зэрэг шинжүүд илэрнэ.

## НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР

<b>АЛДААТАЙ ИТГЭЛ ҮНЭМШИЛ</b>	Танин мэдэхүй, зан үйлийн онолын үндсэн ойлголтын нэг. Хүний гаргаж буй зан байдлын цаад шалтгаан нь алдаатай итгэл үнэмшил буюу нөхцөл байдлыг өөрөөр, урвуулж тусгаж авсантай холбоотой гэж үзээд, алдаатай итгэл үнэмшлийг засаж залруулахад чиглэсэн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг.
<b>АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДРЭМЖ</b>	Ямар нэг аюул, заналхийлэл мэдрээгүй, айдас мэдрэхгүй байхад төрөх дотоод хандлага. Аюулгүй байдлын мэдрэмж нь хүний өссөн орчинтой ихээхэн холбоотой бөгөөд цаашид өөртөө итгэлтэй, зоримог, эрсдэлтэй алхам хийх зэрэг хувь хүний онцлог төлөвшин тогтоход чухал үүрэг гүйцэтгэдэг байна.
<b>БУСДААС ХАМААРАЛТАЙ БАЙДАЛ</b>	Тухайн хүний үзэл бодол, итгэл үнэмшилд бусдын хандлага, байр суурь хүчтэй нөлөөтэй байх, бусдын зүгээс урамшуулал, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ их байхыг хэлнэ. Бага насанд эцэг, эх, ойр дотны хүмүүсийн нөлөөгөөр голчлон тогтдог байна.
<b>ЗУРГАН ЗАСАЛ</b>	Зураг зурах, будах, урлах техникийг ашиглан үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөл, мэдрэмж, айдас зэргийг гадагшлуулах урлагийн сэтгэл заслын нэг хэлбэр.
<b>МЭДРЭМЖ</b>	Хүний гадаад болон дотоод нөхцөл байдлын талаар мэдээллийг хүлээн авах механизм <sup>1</sup> . Мэдрэмж нь гаднаа ил гарахгүй, бусдад анзаарагдахгүй байж болох харьцангуй тогтвортой дотоод хандлага юм.
<b>СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДАЛ</b>	Сэтгэл санааны тухайн үеийн байдал. Түр хугацааны, хувьсан өөрчлөгдөх шинжтэй.
<b>СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭ</b>	Сэтгэл зүйн янз бүрийн үзэгдлийг хэмжих арга барил, хэрэглэгдэхүүн.
<b>СЭТГЭЛ ЗҮЙЧЭЭС ХАМААРАЛТАЙ БАЙДАЛ</b>	Шийдвэр гаргах явцад сэтгэл зүйчийн үзэл бодол, нөлөө ихсэх, хил хязгаар алдагдахыг хэлнэ. Сэтгэл зүйчийн мэргэжлийн алдаа, нөгөө талаар хүүхдийн бие даасан бус байдал нь сэтгэл зүйчээс хэт хамааралтай байдалд хүргэдэг.
<b>СЭТГЭЛ ТҮГШИЛТ</b>	Айх, эмээснээс болж үүсэх сэтгэлийн зовнил, хямрал <sup>2</sup> гэж тодорхойлдог.
<b>НӨХЦӨЛ БАЙДЛЫН СЭТГЭЛ ТҮГШИЛТ</b>	Тухайн цаг үед хүнд гадаад болон дотоод орчноос ирж буй мэдээлэлд санаа зовох шинж. Энэ нь түр зуурын шинжтэй, тухайн стресс үүсгэгч багасахад аяндаа багасах зүй тогтолтой байна.

1 Б.Батсайхан, М.Дэлгэржав. Сэтгэл судлалын бага тайлбар толь. УБ.,2013

2 Б.Батсайхан, М.Дэлгэржав. Сэтгэл судлалын бага тайлбар толь. УБ.,2013

## БИЕ ХҮНИЙ СЭТГЭЛ ТҮГШИЛТ

Хүний төрөлхийн, эсвэл голчлон бага залуу насанд удаан хугацаагаар нөлөөлсөн үйлчлэлийн хариуд тухайн хүний онцлог болон тогтсон бие хүний шинж. Энэ нь харьцангуй бага өөрчлөгдөх, тогтвортой шинж юм.

## СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

Хүн болон амьд организмын гадаад орчны нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх зан байдал. Хүний гадаад болон дотоод орчноос ирж буй мэдээлэлд хэрхэн хандаж байгаа дотоод хандлагыг илэрхийлэн гаргах сэтгэцийн шинж юм.3 Сэтгэл хөдлөл нь богино хугацааны илэрхийлэл боловч тогтвортой илрэх нь тухайн хүний онцлог шинжийг илэрхийлж болно.

## СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ХАРИУ ҮЙЛДЭЛ

Гадаад болон дотоод цочролын хариуд илэрч буй сэтгэл хөдлөлийн байдал. Сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт чанар, сэтгэлийн хөдөлгөөний тогтворт чанар зэрэг нэр томъёогоор хэрэглэх нь бий.

## СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ

Тухайн хүний хувьд цаашдын харилцаа хандлага, мэдрэмж, хувь хүний онцлогт нөлөө үзүүлэхүйц хэмжээний таагүй үйл явдал тохиолдсон байхыг хэлнэ. Сэтгэцийн гэмтлийн нэг онцлог нь амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж буй таагүй үйл явдал нь зөвхөн тухайн хүнд төдийгүй тухайн хүний ойр дотны, эсвэл хөндлөнгийн хэн нэгэнд тохиолдож байхыг биеэр үзэж мэдэрсэн үед авч болдог. Амьдралын үйл явдал нь хүн бүрд өөр өөр байдлаар тусах бөгөөд нэг удаа гүнзгий цочроолд орох, эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн байх зэргээс хамааран ялгаатай хариу үйлдлээр илэрнэ.

## ТҮРЭМГИЙЛЭЛ

Энэ нь бусдад эсвэл өөртөө бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулах байдлаар илэрдэг хүчирхийлэл бүхий үйлдэл, хандлага юм. Түрэмгий шинж хүн бүрд тодорхой хэмжээгээр байдаг боловч зан үйлийн тогтсон хэм хэмжээнд үл нийцэх, мөн өөрт болон бусдад хохирол учруулахуйц хэмжээнд илрэхийг хэвийн бус гэж үзнэ. Ил болон далд хэлбэртэй байж болно.

## ЭЛСЭН ЗАСАЛ

Үйлчлүүлэгчийн тавгүй мэдрэмжийг багасгах, өөрийгөө илэрхийлэхэд нь туслах, дарагдсан мэдрэмж, сэтгэл хөдлөлөө ойлгоход туслах тоглоомын заслын арга юм.

Элс нь шидэх, нухах, бүтээх зэрэг олон төрлийн үйлдэлтэй учраас ухамсаргүйд байгаа мэдээллийг илрүүлэхэд тусалдаг онцгой хэрэгсэл болдог.

## ЭЭНЭГШИЛ

Асран хамгаалагчтайгаа сэтгэл зүйн хувьд холбоо тогтоох явцыг ээнэгшил гэнэ. Ээнэгших үйл явц хангалттай хөгжөөгүй бол зан төлөв, өөрийн үнэлгээ, бусадтай харилцах харилцаа, сэтгэл хөдлөл, түүнийгээ илэрхийлэх гээд хүний амьдралд олон талаар нөлөөлдөг гэж үздэг.



## ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

### ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

#### Зөвлөгөөний өрөө болон орчныг бэлтгэх:

- “ Уулзалт эхлэхээс өмнө зөвлөгөөний өрөөний агаарыг сэлгэх, байгалийн гэрэл туссан байхыг бодож гэрэлтүүлэг гаргах. Хэрэв гаднаас байгалийн гэрэл тусах боломжгүй бол ширээний гэрэл зэргийг асааж болно. Мөн хүүхдэд тухтай мэдрэмж төрүүлэх зорилгоор зөөлөн тоглоом, хүүхдийн ном, хүүхдэд зориулсан орчныг зөвлөгөөний өрөөнд бий болгоорой. Өрөөнд агаар, гэрэл оруулах, хүүхдэд зориулсан орчин бэлтгэх нь үйлчлүүлэгчид чөлөөтэй, тайван мэдрэмжийг бий болгоход тусална.
- “ Зөвлөгөөний өрөөний сандал нь үйлчлүүлэгчид тухтай мэдрэмж төрүүлэхүйц зөөлөн, түшлэгтэй байна. Үйлчлүүлэгч өөрийн биед тухтай байдлаар ашиглах боломжтой дэрнүүдийг бэлтгэнэ. Мөн сэтгэл зүйч болон үйлчлүүлэгч буй хүүхэд сандал дээр суухад ижил харааны түвшин байх ёстой тул сэтгэл зүйчийн сандал үйлчлүүлэгчийн сандалаас бага зэрэг нам байж болно. Хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа тул ширээний 2 талд сандал дээр сууж үйлчилгээ үзүүлэхийг чухалчлахгүй байх. Тухайн уулзалтад ашиглаж буй арга техник, үйлчлүүлэгч хүүхдийн сонголтод тулгуурлан зөөлөн дэр, олбог, дэвсгэр зэрэг дээр сууж болно. Сэтгэл зүйч гар самбар ашиглаж тэмдэглэл хийнэ хэмээн бэлтгээрэй.
- “ Зөвлөгөөний өрөөнд цэцэг, тоглоом зэргийг тавьсан бол үйлчлүүлэгчийн даван туулж буй хүчирхийллийг санагдахуйц, түүнтэй хамааралтай зүйл байгаа эсэхийг нягтлаарай. Мөн зөвлөгөөний эхлэл үед үйлчлүүлэгчээс өрөөнд байгаа зүйлс тухгүй мэдрэмж төрүүлж байгаа эсэхийг тодруулж асуугаарай.
- “ Бусад үйлчлүүлэгч, мэргэжилтнүүд зөвлөгөөний явцад саад болох, сарниулахаас сэргийлж зөвлөгөөтэй байгааг сануулах, илэрхийлэх бичиг өлгөж болно.

#### Хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэхүүн болон бусад бэлтгэл:

- “ Бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа тул олон төрлийн арга техникийг ашиглах шаардлагатай. Иймээс тоглоом, зургийн хэрэгсэл, ном, дүрд орлуулах тоглоом, карт зэргээр хамгаалах байрны нөөцийг ашиглан боломжтой бүх хэрэгслүүдийг ил гаргаж, өөр ширээн дээр тавьж болно. Бүх хэрэгслийг ил байлгах нь үйлчлүүлэгчид сонголт хийх боломжийг олгох бөгөөд сэтгэл зүйч сонголт хийхийг санал болгоно. Мөн гар хүрэхүйц газар хуурай салфетка тавих.
- “ Хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад эрх мэдлийн хувьд тэнцвэртэй мэдрэмж төрүүлэх нь үйлчлүүлэгч нээлттэй байх, итгэл түрүүлэхэд чухал. Хэрэв боломжтой бол дүрэмт хувцас өмсөхгүйгээр үйлчилгээ үзүүлэх нь зохимжтой.
- “ Гар самбарыг бичгийн цаас, бал, уулзалтын тэмдэглэлийн хуудасны хамт бэлтгэх. /Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг Хавсралт 1-т оруулав/
- “ Намуухан ая, байгалийн ая тавих боломжийг бодолцож хөгжмийг урьдчилан бэлтгэх.
- “ Сэтгэл зүйн хөтөлбөрийн багцад орсон стресс тайлах бөмбөг, базах, атгах зориулалттай тайвшруулах хэрэглэгдэхүүн, зургийн хэрэглэгдэхүүн зэргийг ширээнд тавьсан байх.
- “ Хөтөлбөрийн үе шат бүр дэх бэлтгэх зүйлстэй урьдчилан танилцсан байх.
- “ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ уулзалт бүрийг кодолж, үе шатыг дарааллын дагуу хэрэгжүүлэхийг анхаарах.
- “ Уулзалт бүрийн дагуу тэмдэглэл хөтлөх.

## Хүчирхийллийн даван туулагч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхэд анхаарах:

- “ Хүчирхийллийн даван туулагчид үзүүлэх аливаа үйлчилгээ нь сэтгэцийн гэмтэлд суурилсан буюу гэм хор учруулахгүй байх зарчмуудыг баримталдаг. Хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхээс өмнө сэтгэцийн гэмтэлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээний 5 зарчмыг судалж, үйлчилгээнд шингээхийг эрмэлзээрэй.

  - *Аюулгүй байдал* - Үйлчлүүлэгчид сэтгэл зүй болон орчны бүх талаар аюулгүй байна хэмээн мэдрэмжийг төрүүлэхийг эрмэлзэх.
  - *Ил тод, тодорхой байдал* - Сэтгэл зүйн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад үйлчлүүлэгчид эргэлзээ төрүүлэх аливаа зүйлсийг бий болгохгүй байх. Мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг баримтлах.
  - *Сонголтыг чухалчлах* - Эрх мэдэл, шийдвэр гаргах, үйлчилгээний бүхий л хэсэгт сонголт хийх боломжийг олгож, шийдвэрийг хүндэтгэх
  - *Хамтын ажиллагаа* - Үйлчлүүлэгчийн төлөө хийхгүй, үйлчлүүлэгчтэй хамтдаа ажиллана. Илаарьших үйл явц нь хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалтаас эхэлдэг болохыг чухалчлах.
  - *Хүчирхэгжүүлэх* - Үйлчлүүлэгчийн давуу байдал, хүч чадал, эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, давуу байдалд тулгуурлан үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх. Ур чадвар, давуу байдлыг байнга бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх. Үйлчлүүлэгчийн эрхэм чанар, халдашгүй байдал баталгаажих нөхцөлөөр хангах.
- “ Сэтгэл зүйн үйлчилгээнээс гадна бүхий л төрлийн үйлчилгээг хүүхдэд үзүүлэхэд түүнийг хүндэтгэж, хүлээн зөвшөөрч, эрх мэдлийн хувьд тэгш байгааг мэдрүүлэх нь хүүхэд нээлттэй, итгэлтэйгээр харилцах эсэхэд шууд нөлөөлнө. Дээрх сэтгэгдлийг дараах үйлдлүүдээр хүүхдэд мэдрүүлж болно. Тухайлбал:

  - Үйлчлүүлэгч хүүхэд хэн нэгэнтэй хамт байгаа тохиолдолд хүүхэдтэй эхэлж мэндлэх.
  - Хүүхдийн тухай өөрөөс нь асуухыг чухалчилна.
  - Хүүхэдтэй ярилцахдаа харааны ижил түвшинд байх. Түүн рүү харж, хандаж ярилцах.
  - Буруутгах, зэмлэх, сургах өнцгөөс харилцахгүй байх. Үүний тулд хүүхэд бол хүн, насанд хүрэгчтэй ялгаагүй өөрийн бодол, мэдрэмж, туршлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх.
  - Хүүхэд чухал болохыг мэдрүүлж тухайн үеийн сэтгэгдэл, санал зэргийг асууж, оролцуулах.
- “ Хүчирхийллийн даван туулагч хүүхэд нь байнгын айдас, түгшүүрийн мэдрэмжтэй, сэтгэл зүйн хувьд тогтворгүй, өөрийн үнэлэмж доогуур, аюулгүй байдлын мэдрэмж сул, танин мэдэхүй, оюун ухааны хөгжлийн хувьд ижил насны хүүхдүүдээс хоцрогдсон байх тохиолдол байдаг. Ялангуяа урт хугацааны хүчирхийлэлд байсан тохиолдолд тархины хөгжилд хүртэл нөлөөлсөн байдаг. Иймээс үйлчлүүлэгч хүүхдийн насанд тулгуурлан оюун ухаан, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийг тодорхойлж харилцахаас илүү, тухайн үйлчлүүлэгчийн онцлог юу болохыг ажиглаж харилцаарай.
- “ Хүчирхийллийн даван туулагч хүүхэд нь аюулгүй байдлын мэдрэмж сул байдгаас бусадтай харилцаа үүсгэхэд бэрхшээлтэй байдгийг санаж, үйлчлүүлэгчийг хүчлэхгүй алгуурхан харилцаарай.
- “ Хүчирхийллийн даван туулагч хүүхэд нь эзэнгшлийн асуудалтай байх нь түгээмэл байдаг тул сэтгэл зүйч хил хязгаарыг баримтлахад онцгой анхаарах. Өөрөөр хэлбэл “зөвхөн надтай ингэж харилцаж байна” гэх онцгойлсон мэдрэмжийг төрүүлэхгүй байх үүднээс биеийн шууд харилцаа үүсгэх, онцгойлсон халамж үзүүлэх зэргээс зайлсхийж, үйлчилгээ үзүүлж байгаа гэдгийг үг, үйлдлээрээ байнга сануулж байх. Тухайлбал доорх үйлдлүүдээр илэрхийлж болно.

- “ Хүчирхийллийн даван туулагч хүүхэд нь байнгын айдас, түгшүүрийн мэдрэмжтэй, сэтгэл зүйн хувьд тогтворгүй, өөрийн үнэлэмж доогуур, аюулгүй байдлын мэдрэмж сул, танин мэдэхүй, оюун ухааны хөгжлийн хувьд ижил насны хүүхдүүдээс хоцрогдсон байх тохиолдол байдаг. Ялангуяа урт хугацааны хүчирхийлэлд байсан тохиолдолд тархины хөгжилд хүртэл нөлөөлсөн байдаг. Иймээс үйлчлүүлэгч хүүхдийн насанд тулгуурлан оюун ухаан, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийг тодорхойлж харилцахаас илүү, тухайн үйлчлүүлэгчийн онцлог юу болохыг ажиглаж харилцаарай.
- “ Хүчирхийллийн даван туулагч хүүхэд нь аюулгүй байдлын мэдрэмж сул байдгаас бусадтай харилцаа үүсгэхэд бэрхшээлтэй байдгийг санаж, үйлчлүүлэгчийг хүчлэхгүй алгуурхан харилцаарай.
- “ Хүчирхийллийн даван туулагч хүүхэд нь эзэнгшлийн асуудалтай байх нь түгээмэл байдаг тул сэтгэл зүйч хил хязгаарыг баримтлахад онцгой анхаарах. Өөрөөр хэлбэл “зөвхөн надтай ингэж харилцаж байна” гэх онцгойлсон мэдрэмжийг төрүүлэхгүй байх үүднээс биеийн шууд харилцаа үүсгэх, онцгойлсон халамж үзүүлэх зэргээс зайлсхийж, үйлчилгээ үзүүлж байгаа гэдгийг үг, үйлдлээрээ байнга сануулж байх. Тухайлбал доорх үйлдлүүдээр илэрхийлж болно.
  - Уулзалтын цаг дуусаж байгааг сануулахдаа “дараагийн хүүхэдтэй уулзах цаг болсон байна. Дараагийн уулзалт хүртэл ... минут үлдсэн байна” хэмээн хэлж болно. Хэрэв 3-5 насны, хараахан цаг мэдэхгүй хүүхэд бол удахгүй уулзалтын хугацаа дууслаа. Дараагийн хүүхэд сэтгэл зүйчтэйгээ уулзахаар хүлээж байгаа” гэх мэтээр хэлж болно.
  - Мэдрэмжийг тайвшруулсан үг хэлэхдээ “Сэтгэл зүйч нь чамтай ижил асуудлыг даван туулж байгаа олон хүүхэдтэй уулздаг. Тэр хүүхдүүдийн дийлэнх нь яг ийм мэдрэмжтэй байдаг.
  - Дараагийн уулзалтын цаг товлохдоо “Хоёулаа өдрийн хоолоо идэхээс чинь өмнө уулзах уу? Чамтай уулзсаны дараа 2 хүүхэдтэй уулзах юм байна” хэмээн хэлж болно. Мөн үйлчлүүлэгч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогийг харгалзаж хэрхэн хэлэх тухай анхаараарай.
  - Хүүхдийг тайвшруулахдаа тэврэх, өвөр дээр суулгах зэрэг биеийн харилцаа үүсгэхгүй. Хүүхэд тайвшрахгүй удах, биед нь хүрэхээс өөр аргагүй нөхцөлд гар дээр нь хөнгөн илэх, товших зэргээр хүрж болно.
- “ Даван туулагч хүүхэд нь нийгмийн харилцаанд оролцсон туршлага бага, айдастай, нийгэмшил бага байх нь түгээмэл байдаг. Иймээс нийгмийн ажилтан, багш нартай хамтран кейс төлөвлөгөө гаргаж ажиллаарай.
  - Хүүхдийн сэтгэл зүйн асуудлын суурь шалтгаан нь гэр бүл, нийгмийн хүрээллээс шалтгаалдаг тул эцэг эхтэй хамтран ажиллаж, суурь шалтгааныг бууруулахад чиглэж ажиллана.
  - Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхэд, эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлог, хүчирхийллийн онцлог, бие махбод болон сэтгэл зүйд гарах үр дагаврын тухай урьдчилан судалсан байх.
  - Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн болон бие махбодын талаас илэрч буй шинж тэмдгүүдийг нарийн анхаарах. Үйлчлүүлэгчээс асуух, ажигласан зарим шинжүүдийг үйлчлүүлэгчид хэлэх байдлаар тодруулж асуух.
  - Мэдрэмжээ чөлөөтэй илэрхийлэхэд саад болохгүй байх, жишээ нь, тайвшир, битгий уйл гэх мэт үгсийг ашиглахаас зайлсхийх.

## Сэтгэл зүйчийн хувийн бэлтгэлтэй холбоотой анхаарах зүйлс

- “ *Сэтгэл зүйн тестийн заавар, үр дүнг гаргах аргыг эзэмшсэн байх*, уулзалтын өмнө эцэг эх, асран хамгаалагч эсвэл үйлчилгээнд зуучилсан мэргэжилтнээс хүүхдийн нөхцөл байдлын тухай мэдээлэл авсан байх
- “ *Сэтгэл зүйч уулзалтын өмнө өөрийн сэтгэл зүйг бэлтгэх*: үйлчлүүлэгчийн асуудалтай адил өөрт тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн, эсвэл ийм асуудалтай тулгарч байгаагүй байх, уулзалтын өмнө болон тухайн үед тайван, айдас түгшүүргүй байх /хэрэв тийм бол зөвлөгөө өгөхөөс татгалзах/
- “ *Хувцаслалт*: ажил хэрэгч, хэт задгай буюу цээж, хөлийн хуруу, шагай ил гараагүй байх, гэрэлтээгүй, юбка өмсөх бол өвдгөөр татсан болон өвдөгнөөс доош урттай байх
- “ *Нүүр будалт, гоёл*: өдөр тутмын буюу хэт тод, гүн будалт хийхгүй байх, гоёл нь хэт чамин, гялгар, үнэтэй биш байх зэргийг шалгаж зохих хэмжээнд байлгахад анхаарна.

## СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЯВЦАД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

### Сэтгэл зүйн арга, аргачлалыг ашиглах явцад анхаарах, бэлтгэх:

#### *Тайвшруулах дасгал, аргуудыг ашиглах явцад доорх зүйлсийг анхаарах:*

- Үйлчлүүлэгчид санал болгож буй тайвшруулах аргыг ажиллуулахаас өмнө тухайн дасгалын ач холбогдол, үзүүлэх эерэг нөлөө, ямар учраас энэ дасгалыг санал болгож буй зэргийг үйлчлүүлэгчийн нас, сэтгэл зүйн онцлогт тохиромжтой байдлаар тайлбарлах. Хүүхдэд тайлбарлахдаа зураг, дүрс, тоглоом ашиглах нь илүү тохиромжтой.
- Тайвшруулах дасгалын явцад үйлчлүүлэгчийн бие махбод, сэтгэл зүйг бэлтгэнэ.

*Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйг бэлтгэх.* Үйлчлүүлэгчид урт хугацаа шаардах тайвшруулах дасгалыг анх заахдаа сэтгэл хөдлөл тайван бус нөхцөлд заахаас зайлсхийгээрэй. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчид үр дүнгүй санагдаж, тайвшруулах дасгалд итгэх итгэл буурч, өөрийн сэтгэл хөдлөлийг зохицуулах сэдэл буурах эрсдэлтэй. Иймээс энэ тохиолдолд сэтгэл зүйч үйлчлүүлэгчтэй ярилцах арга, зургийн арга, богино хугацааны тайвшруулах амьсгалын дасгал, булчингийн дасгал зэрэг жижиг аргачлалуудаар ашиглаж үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлийг тогтворжуулна.

*Үйлчлүүлэгчийн бие махбодыг бэлтгэх.* Үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөл харьцангуй тогтвортой байгаа тохиолдолд тайвшруулах амьсгалын дасгал болон бусад дасгалыг зааварчилгааны дагуу хийлгэнэ. Дасгал хийлгэхийн өмнө болон дасгалын явцад үйлчлүүлэгчийн бие махбодыг тайван эсвэл тайван бус байгааг ажиглана. Дасгал бүрийн өмнө нийтлэгээр үйлчлүүлэгчийг хөлөө улаар нь бүрэн гишгэж, биеэ суллаж суухыг сануулдаг. Дасгал хийх явцад үйлчлүүлэгчид зовууртай байгаа эсэх, зааварчилгааны дагуу ажиллахад хүндрэлтэй байгаа эсэхийг ажиглаарай. Хэрэв таагүй байгаа мэт ажиглагдвал дасгалыг зогсоож болохыг сануулаарай.

#### *Сэтгэл зүйн тест болон проектив аргуудыг ашиглаж үнэлгээ хийх явцад анхаарах:*

- Тест болон бичих шаардлагатай үнэлгээний аргыг ашиглах тохиолдолд үйлчлүүлэгч унших, бичих боломжтой бол өөрөөр нь ажиллуулахыг санал болгоно. Хэрэв боломжгүй бол сэтгэл зүйч асууж ярилцах замаар хариулыг бичнэ. Ингэхдээ байцааж байгаа мэт асуухгүй байх, асуултын агуулгаас гажсан тайлбар хийхгүй байх, үйлчлүүлэгчийн хариулыг чиглүүлэхгүй байх зэргийг мэргэжилтэн анхаарна.

- Хөтөлбөрт багтсан проектив аргуудыг ашиглахдаа үйлчлүүлэгчид картуудыг барьж үзэх, эргүүлж харах, зургуудад боловсруулалт хийх хугацааг олгоно. Проектив арга нь мэргэжилтнээс асуултыг оновчтой асуух, чиглүүлж ярилцах, эмпати чадвар зэргийг шаарддаг. Сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрт 2 болон 3 дахь уулзалтад проектив аргыг ашиглахыг санал болгосон бөгөөд эдгээр аргыг үйлчлүүлэгч, сэтгэл зүйч хооронд итгэлт харилцаа тогтсон тохиолдолд ашигладаг.

**Үйлчлүүлэгчид гэрийн даалгавар өгөх:** Хөтөлбөрт багтах уулзалт бүрийн төгсгөлд дараагийн уулзалт хүртэл үйлчлүүлэгч өөрийн сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарч, сэтгэл хөдлөлөө тогтворжуулах зорилготой ажлуудыг гэрийн даалгаварт өгдөг. Үйлчлүүлэгчид даалгаврыг санал болгохдоо түүний санал, сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл, дэмжлэг үзүүлэх боломжтой хүмүүс байгаа эсэх, амьдарч буй орчны нөхцөл байдал зэргийг харгалзан даалгаврыг өгнө. Ихэвчлэн хөнгөн, богино хугацаа шаардах ажлуудаас урт хугацаа шаардах ажлууд руу бага зэрэг хүндрүүлж даалгаврыг өгнө. Үйлчлүүлэгч даалгаврыг гүйцэтгээгүй тохиолдолд хүндрүүлэхгүй байхыг анхаарах.

### Тэмдэглэл хийх, хөтлөхтэй холбоотой анхаарах зүйлс:

Сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сэтгэл зүйн уулзалтын тэмдэглэлийн хуудас, сэтгэл зүйн үнэлгээний хуудас зэргийг хөтөлнө. Эдгээрийг хөтлөхдөө уулзалтын явцад өөрт сануулах үүднээс түлхүүр үг ашиглан тэмдэглэж, уулзалтын дараа түлхүүр үгсийг дэлгэрүүлэн бичихийг санал болгож байна. Учир нь үйлчлүүлэгчийн дэргэд байнга тэмдэглэл хөтлөх нь нээлттэй харилцаа үүсгэхэд хаалт болж болзошгүй.

#### Уулзалтын тэмдэглэлийн хуудас хөтлөх /Хавсралт 1/:

- **Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл.** Энэ хэсэгт хамгаалах байр, НЦҮТ-ийн журмын дагуу үйлчлүүлэгчийн кейсийг кодолж үйлчлүүлэгчийн код хэсэгт тэмдэглэнэ. Мөн үйлчлүүлэгчийн нас, хүйсийг тэмдэглэж, тухайн үйлчлүүлэгч ямар хүчирхийлэлд өртсөний улмаас хамгаалах байр, НЦҮТ-өөр үйлчлүүлэх болсныг ✓ тэмдгээр тэмдэглэнэ.
- **Үе шат, уулзалтын тэмдэглэл.** Энэ хэсэгт хөтөлбөрт багтах уулзалт бүрийг явуулсан өдөр, уулзалтад ашиглаж буй сэтгэл зүйн арга техник, үнэлгээний үйл явц зэргийг тэмдэглэнэ. Мөн хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлогоос шалтгаалж дараагийн уулзалтыг өөр мэргэжилтэн чиглүүлэх боломжтой байдгийг харгалзаж дараагийн мэргэжилтэнд кейстэй хамааралтай анхаарах зүйл, сэтгэл зүйн арга аргачлалыг ашиглах явцад гарсан ажиглалт, үр дүнг тайлбар хэсэгт нарийн тэмдэглэж үлдээнэ.
- **Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн.** Энэ хэсэгт үйлчлүүлэгч сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдахаас өмнө хүчирхийллээс шалтгаалж (хүчирхийлэлтэй хамааралтай эсэхийг нарийн хэлэх боломжгүй тохиолдолд заавал хамааралтай байхыг шаардахгүй) бие махбод, сэтгэл зүй, зан үйлд илэрч буй илрэл, шинж тэмдэг, өөрчлөлтийг сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх явцад уулзалт бүрийн дараа тэмдэглэнэ. Мөн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид гарч буй үр дүн, ажиглалт, ахиц, суралцаж буй ур чадвар, дадал зэргийг үйлчлүүлэгчид гарсан сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн хэсэгт тэмдэглэнэ. Хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлогоос шалтгаалж урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, тодорхой үр дүнд хүрэхэд хязгаарлагдмал байх тул үр дүн хэсэгт том өөрчлөлтийг бичихээс илүү тухайн уулзалтын явцад болон дараа үйлчлүүлэгчид сэтгэл хөдлөл, мэдрэмж, бодлын түвшинд гарч буй багахан өөрчлөлтийг ажиглаж бичихэд хангалттай. Энэ нь кейс бүртгэлд шаардлагатайгаас гадна сэтгэл зүйчийг ажлаас халшрах хам шинжид өртөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

**Сэтгэл зүйн үнэлгээний хуудас хөтлөх /Хавсралт 2/:**

- Сэтгэл зүйн үнэлгээний хуудаст тухайн хөтөлбөрийн туршид ашиглах арга, аргачлалын зорилго, онцлог, бэлтгэх зүйлс, үйлчлүүлэгчид тайлбарлах зааварчилгаа, тухайн аргыг ашиглахад гарсан үр дүнг дараагийн уулзалт болон сэтгэл зүйн үйлчилгээнд хэрхэн ашиглах тухай товч оруулсан. Мөн тухайн арга аргачлалын явцад ашиглах хэрэглэгдэхүүн, ажлын хуудсыг хавсаргасан.
- Сэтгэл зүйч урьдчилан тухайн сэтгэл зүйн үнэлгээний аргуудтай танилцаж, бэлтгэл ажлыг хангаж, уулзалтад ашиглана.

**ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ****Хөтөлбөрийн үр дүнг Хавсралт 1.**

“Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ын дагуу үйлчлүүлэгчтэй хийх уулзалт бүрийн явцад хөтөлнө. Үүнд:

- ⦿ Эхний сэтгэл зүйн уулзалтын дараа ‘Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл’,
- ⦿ Уулзалт бүрийн явцад ‘Үе шат, уулзалтын тэмдэглэл’

Дөрөв дэх уулзалтын төгсгөлд ‘Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн’ хэсгийн дагуу тэмдэглэл хийж, үйлчлүүлэгчид үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн, ахицыг үнэлнэ.

## ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ, ЗААВАРЧИЛГАА

### ХӨТӨЛБӨРТ ШААРДАГДАХ АРГАЧЛАЛ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

#### 1 ЭЛСЭН ЗАСЛЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Элсэн заслыг сэтгэл зүйн ачааллыг багасгах, тайвшруулах, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг зорилгоор ашигладаг. 50×70×8 см хэмжээтэй модон хайрцаг, нарийн ширхэгтэй элс, хүний эргэн тойронд байж болох зүйлсийг дүрсэлсэн жижиг тоглоомууд ашиглана. Модон хайрцгийн дотор тал гол төлөв цэнхэр өнгөтэй байна.

#### 3 ГАР ТЕСТ

Хүүхдийн харилцаа, сэтгэл хөдлөлийн онцлогийг илрүүлэх аргачлал бөгөөд 4-с дээш насны хүүхдэд хэрэглэж болно. Гарын зургуудыг харуулж, гарын эзэн юу хийж байж болох талаар хүүхдийн төсөөлөлд дүн шинжилгээ хийнэ.

#### 5 ЗУРГАН ЗАСЛЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНҮҮД

Зурган заслын аргыг хүүхдийг тайвшруулах, сэтгэл зүйн ачааллыг багасгах, мэдрэмжээ илэрхийлэх зэрэг зорилгоор өргөн хэрэглэдэг. Өнгийн харандаа, зургийн бусад хэрэгслийг ашиглана.

#### 7 АШИГТАЙ БОЛОН АШИГГҮЙ БОДЛЫН ТАЛААР ЗУРАГТ ХУУДАС

Танин мэдэхүй, зан үйлийн сэтгэл заслын үед хүүхдийн алдаатай бодлыг илрүүлэх, засах зорилгоор хэрэглэдэг.

#### 2 ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ТҮГШИЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ ТЕМПЛ ДОРКИ НАРЫН АРГАЧЛАЛ

Ялгаатай нөхцөл байдлын үед хүүхдэд илрэх сэтгэл түгшилтийг тодорхойлох тусгалын аргачлал юм. Охид ба хөвгүүдийн хувилбар бүхий 14 зургийг харуулж тохирох нүүрний зургийг сонгуулдаг бөгөөд 3 наснаас эхлэн хэрэглэж болдог.

#### 4 ДУУСГААГҮЙ ӨГҮҮЛБЭРИЙН АРГА

Дуусгаагүй өгүүлбэрийн арга нь хүүхдийн эцэг эх, гэр бүл, орчин, найз нөхөд болон өөртөө хандах хандлагыг илрүүлэх нийт 24 асуулттай.

#### 6 СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН КАРТ

Янз бүрийн сэтгэл хөдлөлийг харуулсан зургуудыг харуулж ярилцана. Бүлгийн болон ганцаарчилсан уулзалтад ашиглах боломжтой. Хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээнд нөхцөл байдалд үзүүлэх хариу үйлдэл болон өөрийн сэтгэл хөдлөлийг хэр таньж байгаа, сэтгэл хөдлөлийн илэрхийлэмж, одоогийн сэтгэл зүйн байдал зэргийг илрүүлж болно.

## НЭГ. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДРЭМЖ БИЙ БОЛГОХ, ТААЛАМЖГҮЙ МЭДРЭМЖИЙГ БУУРУУЛАХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө бэлтгэх зүйлс:

- Уулзалтад ашиглах элсэн заслын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх. Хэрэв үйлчлүүлэгч элстэй ажиллахыг хүсэхгүй байвал өөр хэрэглэгдэхүүнээс сонголт хийх нөхцөлийг бүрдүүлэх.
- Хүүхэд элсийг норгож тоглохыг хүсвэл ашиглах устай сав, нойтон салфетка зэргийг бэлтгэх.
- Сэтгэл зүйч үйлчлүүлэгчид зааварчилгаа өгч өөрийн мэддэг богино хэмжээний амьсгалын дасгал эсвэл хөтөлбөрт дурдсан амьсгалын дасгалыг хийлгэхэд бэлтгэх. Амьсгалын дасгал хийхэд өөрт тухтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор нуруунд ивэх жижиг дэрийг бэлтгэх.
- Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./



### Уулзалтын зорилго:

- Сэтгэл зүйч, үйлчлүүлэгч хооронд таатай, дулаан, итгэлт харилцаа бий болгох.
- Үйлчлүүлэгчийг тайвшруулах, тааламжгүй мэдрэмжийг гадагшлуулах.

### АЛХАМ 1. Харилцаа холбоо үүсгэх /15 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Юуны түрүүнд хүүхдэд өөрийгөө танилцуулж, түүнээс өөрийгөө танилцуулахыг хүсээрэй. Хүүхэд хэнтэй хамт зөвлөгөөний өрөөнд орж ирснээс үл хамааран хүүхэдтэй хамгийн түрүүнд мэндэлнэ.</li> <li>- Сэтгэл зүйч өөрийгөө болон сэтгэл зүйн үйлчилгээг хүүхдэд ойлгомжтой байдлаар тайлбарлана. Сэтгэл зүйчтэй уулзсанаар ямар үр дүнд хүрч болох, юунд чиглэх тухай энгийн жишээ ашиглаж хүүхэдтэй ярилцана.</li> <li>- Сэтгэл зүйч хүүхдээс хамгаалах байранд байрлах нь ямар санагдаж байгаа тухай асууж, хамгаалах байрны тухай зөрүүтэй ойлголт, түүнээс шалтгаалсан тааламжгүй мэдрэмж байгаа эсхийг тодруулж, түүнийг залруулж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эхний уулзалтаар хүүхдэд найрсаг, өөрийг нь хүндэтгэж байгаа, аюулгүй мэдрэмжийг төрүүлснээр цаашдын сэтгэл зүйн үйлчилгээ үр дүнтэй байна.</li> <li>- Зарим хүүхдийн хувьд харилцахгүй, ярилцахгүй байх нь үйлчилгээнд хамрагдахыг хүсэхгүй байна гэсэн үг биш. Тиймээс үйлчлүүлэгчийн өмнөөс дүгнэхээс илүү түүнийг бодол, мэдрэмжийг асуугаарай.</li> </ul>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> <li>- Түр хамгаалах байр, НЦҮТ-ийн журам, үйлчилгээний маягтуудын дагуу хүүхэд болон асран хамгаалагчтай гэрээ байгуулна.</li> <li>- Уулзалтын тэмдэглэлийн хуудасны дагуу тэмдэглэл хөтөлнө.</li> </ul>	



## АЛХАМ 2. Тайвшруулах / 25 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Энэ хэсэгт элсэн заслын хэрэглэгдэхүүн ашиглаж хүүхдэд мэдрэмжээ гадагшлуулах, тайвшрах боломжийг олгоно.</li> <li>- Хүүхэдтэй элсээр тоглох тухай яриа өрнүүлж, яг одоо элсээр тоглохыг хүсэж байгаа эсхийг лавлаарай. Хэрэв хүүхэд хүсэхгүй байгаа тохиолдолд хүчлэхгүйгээр өөр юу хийхийг хүсэж байгааг асуугаарай. Хүүхэд хариулж мэдэхгүй байвал ашиглаж болох зүйлсийг өрсөн тавиур/ширээн дээрээс сонголт хийхийг санал болгоно. Хэрэв үйлчлүүлэгч элсээр тоглохыг сонгоогүй тохиолдолд сонгосон өөр хэрэгслийг ашиглаж, мэдрэмжээ гадагшлуулах, ярилцахад нь дэмжээрэй.</li> <li>- Хэрэв хүүхэд элсээр тоглохыг хүссэн бол элсэн заслын хэрэглэгдэхүүнийг ашиглаж тайвшруулах, мэдрэмжээ гадагшлуулахад дараах байдлаар чиглүүлнэ. <ul style="list-style-type: none"> <li>o “Хоёулаа хамт элсээр бороо оруулах уу? Чи өмнө нь элсээр бороо орж байна гэж тоглож үзсэн үү?” гэх мэтээр ярилцлага өрнүүлнэ.</li> <li>o Сэтгэл зүйч үйлчлүүлэгчид тайлбарлахдаа дараах байдлаар хэлээрэй. “Би чамд ямар бороо орж байгааг хэлье. Чи элсийг борооны дусал хэмээн бодож миний хэлсэн бороо хир хүчтэй, зөөлөн ордог болохыг санаад, элсээр үзүүлээрэй. Ингэхдээ гараа атгаж, элсээ хурууныхаа завсраар урсгах байдлаар үзүүлээрэй”</li> <li>o “Бороо ороогүй байна. Бороо дусалж байна... Бороо намуухан шивэрч байна ... Бороо аажмаар багасаж байна... Бороо буцаад зөөлөн шивэрч байна... Бороо шаагьж байна... Маш хүчтэй ширүүн бороо орж байна... Бороо улам бүр ширүүсэж байна... Бороо аажмаар зогсож байна... Бороо зогслоо” гэх мэтээр 5 минутын турш ажиллана.</li> <li>o Дээрх дасгалын дараа хүүхдэд арай нээлттэй байдал бий болсон байх тул хүүхэд элсээр чөлөөтэй тоглохыг хүсэж болно. Элсэн дээр зураг зурах, бөмбөг хийх, байшин барих зэргээр хамтран бүтээлчээр ажиллаарай.</li> </ul> </li> <li>- Үүний дараа хүүхдэд элсэн заслын тоглоомуудыг танилцуулж, дүрд орлуулан тоглохыг санал болгоорой. Хүүхэд тоглож байх явцад сэтгэл зүйч ярилцаж, мэдрэмжийг нь гадагшлуулах, таниулахад анхаарч ажиллана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдэд сонголтыг санал болгох нь нээлттэй, итгэлтэй харилцаа үүсгэхээс гадна үйлчлүүлэгч өөрийгөө анзаарах, одоо цагт болон өөрт төвлөрөх боломжийг олгодог. Иймээс хүүхдийг хүчлэхгүй, тулгахгүй байхыг сайтар анхаарах.</li> <li>- Элсэн заслын аргыг ашиглахдаа сэтгэл зүйч хүүхэдтэй хамтдаа тоглоно. Хүүхдэд дан даалгавар өгч тоглуулах нь хяналтад байгаа мэт мэдрэмж үүсгэж, түгшүүрийг нэмэгдүүлдэг.</li> <li>- Үйлчлүүлэгч хүүхэд элсээр тоглох үед заавал идэвхтэй, хөгжилтэй байх албагүй бөгөөд энэ тохиолдолд сэтгэл зүйч хэвийн хэмээн хүлээн авч, хүүхдийг хүчлэхгүй байхыг хичээгээрэй.</li> <li>- Хүүхдэд бие махбодыг нь ажиглуулахын тулд гарт элс хэрхэн мэдрэгдэж байгаа, элсийг олон хэв шинжид оруулахад мэдрэмж өөрчлөгдөж байгаа эсэх энгийн асуулуудаар яриа өрнүүлээрэй.</li> <li>- Хүүхэд элсээр үргэлжлүүлэн тоглохыг хүсвэл боломж олгоорой. Урт хугацаа шаардвал уулзалтын дараа үргэлжлүүлэн тоглохыг санал болгоорой.</li> </ul>
<h3>Хэрэглэгдэхүүн / Арга барил</h3>	
<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг дагалдах элсэн заслын хэрэглэгдэхүүн</li> <li>- Бусад ашиглах боломжтой зургийн хэрэгсэл, ном, тоглоом зэрэг хэрэглэгдэхүүнүүд</li> </ul>	

### АЛХАМ 3. Батжуулалт, дүгнэлт /10 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Өнөөдрийн уулзалт болон элсээр тоглох нь ямар санагдсан тухай яриа өрнүүлж, түүнийг дэмжиж ярилцаарай.</li> <li>- Хэрэв хүүхэд хүсвэл амьсгалаа ажиглаж, зөв амьсгалах богино дасгал зааж өгнө. Хөтөлбөрт санал болгож буй амьсгалын дасгалыг эсвэл сэтгэл зүйч өөрийн сайн мэддэг амьсгалын дасгалыг хүүхдэд санал болгож, зааж өгөөрэй.</li> </ul> <p><b>Санал болгож буй амьсгалын дасгал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>o Намуухан ая тавина. Хүүхдийг гэдсэн дээрээ гараа тавьж, хэвлийгээ мэдрэнгээ өөрийн энгийн үед амьсгалдаг байдлаар амьсгалахыг санал болгоно. 3-5 удаа амьсгал авч, гаргасны дараа амьсгал авах, гаргах үед гэдэс хэрхэн хөдөлж байсан тухай ярилцаарай.</li> <li>o Амьсгалын дасгалын хувилбар. 2 гарын алгаа дээш нь харуулахыг хүүхдэд санал болгоно. Баруун гар дээр гоё үнэртэй цэцэг, зүүн гарын алган дээр лаа байна гэж төсөөлүүлнэ. Цэцэгээ үнэртлээ, лаагаа үлээж байна зэргээр хийлгэж болно.</li> <li>o Сэтгэл зүйн байдал тайван, тогтвортой байх үед хүн хэвлий хүртэл бүрэн амьсгалж, амьсгал авах гаргахтай зэрэгцэж хэвлийн булчин агшиж бас суларч байдаг. Харин стресстэй, тааламжгүй мэдрэмжтэй байх үед цээж хүртэл богино замаар амьсгалж, биеийн булчин бүхэлдээ чангарсан байх нь түгээмэл.</li> <li>o Хэрэв үйлчлүүлэгч амьсгал авах үед гэдэс төвийж, амьсгал гаргах үед гэдэс татагдсан бол энэ зөв буюу тайван байх үеийн амьсгал юм.</li> <li>o Хүүхдэд зөв амьсгалын тухай тайлбарлаж, хэвлийгээ ажиглаж, амьсгалын дасгал хийхийг санал болгож, хамтдаа 8-10 удаа хэвлий дээрээ гараа тавьж, гүнзгий амьсгал авах дасгал хийнэ.</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>- Амьсгалын дасгал хийхэд биед ямар мэдрэмж төрсөн тухай ярилцаж, гэрийн даалгаварт хамгийн багадаа өдөрт 3 удаа хийхийг санал болгоорой. Амьсгалын дасгалыг тайван, тухтай орчинд хийнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Амьсгалын дасгал хийхэд нүдээ аних нь төвлөрөх, бие махбодоо мэдрэхэд тустай байдаг. Гэвч сэтгэл зүйч, үйлчлүүлэгчийн хооронд итгэлтэй харилцаа үүсээгүй байх тохиолдолд үйлчлүүлэгчийн түгшүүрийн мэдрэмжийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй.</li> <li>- Амьсгалын дасгалыг хүүхдэд заахдаа гэдсийг шаар хэмээн төсөөлүүлж болно. Үлээх үед шаар томорч, хий гаргах үед жижиг болдогтой адилгаж тайлбарлаж болно.</li> <li>- Амьсгалын дасгалыг тайван байх үедээ хийж сурах, дадал болох нь сэтгэл санааны байдал тогтворгүй, таагүй мэдрэмжтэй байх үед чармайлт шаардахгүйгээр хийхэд ач холбогдолтой.</li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Тухтай, тайван орчин бүрдүүлэх.</li> <li>- Амьсгалын дасгалын зааварчилгааг хэвлэж болно.</li> <li>- Намуухан ая</li> </ul>	

## ХОЁР. СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө бэлтгэх зүйлс:

- Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./
- Сэтгэл зүйн үнэлгээ хийх уулзалтын зааварчилгаанд дурдсан үнэлгээний аргачлалуудтай танилцаж, уулзалтын үеэр ашиглах карт болон хэрэглэгдэхүүнийг бэлтгэх /Хавсралт 2/
- Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ оноогоор илэрхийлэх шугам /Хавсралт 4./
- Хүчирхийллийн даван туулагч хүүхдэд илрэх сэтгэл зүй болон бие махбодын онцлог, нийтлэг илрэх зан үйлийн өөрчлөлт зэргийг урьдчилан судалсан байх.



### Уулзалтын зорилго:

- Хүүхдийн тааламжгүй мэдрэмж, тэр дундаа түгшүүр, айдас болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, харилцааны онцлог зэргийг тодорхойлох зорилгоор сэтгэл зүйн үнэлгээ хийж, сэтгэл хөдлөл, мэдрэмжийг үйлчлүүлэгчээр ажиглуулах зорилготой.

### АЛХАМ 1. Сэргээн санах, харилцаа үүсгэх /15 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Эхний удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө уулзалтад хамтдаа суралцсан амьсгалын дасгалыг уулзалтаас хойш хийсэн эсэх, ямар мэдрэмж төрсөн, хийхэд бэрхшээлтэй байсан эсэх тухай асууж, ярилцана. Мөн хамгаалах байранд байхад ямар байгаа тухай мэдрэмжийг гадагшлуулан ярилцаарай. Хэрэв эхний болон хоёр дахь уулзалтад нэг сэтгэл зүйч оролцож байгаа тохиолдолд өмнөх уулзалтаар үйлчлүүлэгчтэй ярьсан сэтгэл хөдлөл, бие махбодын шинж тэмдгийг одоо хэрхэн мэдрэгдэж байгааг асууж болно. Энэ нь үйлчлүүлэгчид өөрийг нь мартаагүй, чухал хэмээн үзэж байгааг мэдрүүлнэ. Хэрэв үйлчлүүлэгч амьсгалын дасгалыг хийгээгүй эсвэл хэрхэн хийх зааварчилгааг мартсан тохиолдолд дасгалыг дахин сануулж хамтдаа 3-5 удаа хийгээрэй.</li> <li>- Уулзалтын уур амьсгалыг таатай болгож, үйлчлүүлэгч тайвширсны дараа сэтгэл зүйн үнэлгээ хийх хэсэгт шилжинэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэв үйлчлүүлэгч гэрийн даалгавар буюу амьсгалын дасгалыг хийгээгүй тохиолдолд буруутгахгүйгээр тухайн үйлчлүүлэгчийн даван туулж буй асуудалтай хамааралтай хэмээн ойлгож, дараагийн удаа хийхийг хичээхийг сануулаарай.</li> <li>- Сэтгэл зүйн байдлыг оноогоор үнэлүүлэх нь сэтгэл хөдлөлөө нэрлэж, илэрхийлж чадахгүй байгаа үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлыг мэдэрч ойлгох, үйлчлүүлэгчийг өөрөөр нь анзааруулахад ашигладаг арга юм.</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>- Одоогийн сэтгэл зүйн байдал болон өмнөх уулзалтаас хойш сэтгэл зүйн байдал ямар байгааг 0-10 хүртэлх оноогоор үнэлүүлнэ. Оноогоор хэрхэн үнэлэх тухай доорх байдлаар тайлбарлаарай.             <ul style="list-style-type: none"> <li>o 0-10 хооронд оноогоор үнэлэхдээ оноотой өөрийн сэтгэл зүйн байдал, мэдрэмжийг дүйцүүлж бодоорой.</li> <li>o 0 бол маш тааламжгүй байгаа сэтгэл хөдлөлтэй дүйцнэ. Маш их түгших, айх, гуниглах, уурлах, стрессдэх гээд хүчтэй мэдрэгдэж байгаа тааламжгүй сэтгэл хөдлөлтэй дүйцнэ.</li> <li>o 5 бол хэвийн, тайван, тогтвортой байдалтай дүйцнэ.</li> <li>o 10 бол маш таатай байгаа сэтгэл хөдлөлтэй дүйцнэ. Маш хүчтэй баярлах, хөөрөх, догдлох, бахархах гэх мэт хүчтэй мэдрэгдэж байгаа таатай сэтгэл хөдлөлүүд хэмээн төсөөлөөрэй. Энэ байдлаар 0-10 хооронд тоогоор үнэлээрэй.</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэв цэцэрлэгийн насны эсвэл 10 хүртэлх тоо мэдэхгүй хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа бол хэд хүртэл тоо мэдэж байгааг асууж, цөөн тоогоор эсвэл гарын хурууг ашиглаж сэтгэл хөдлөл, мэдрэмжийг үнэлүүлээрэй.</li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Эхний уулзалт буюу Аюулгүй байдлын мэдрэмж бий болгох, тааламжгүй мэдрэмжийг бууруулах уулзалтад хөтөлсөн Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.</li> <li>- Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ оноогоор илэрхийлэх шугамыг хэвлэн, ашиглаж болно.</li> </ul>	

## АЛХАМ 2. Сэтгэл зүйн үнэлгээ хийх /20-40 хүртэл минут (Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, хурдаас шалтгаалж үргэлжилнэ/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Дараагийн хэсэгт үйлчлүүлэгч хүүхдийн түгшүүр, харилцааны онцлог, хандлага зэргийг тодорхойлно. Хүүхдэд тайлбарлахдаа дараагийн хэсэгт чамд төрдөг тааламжгүй мэдрэмж, бусад сэтгэл хөдлөлүүд, түүнийгээ хэрхэн илэрхийлж, зохицуулдаг болохыг хамтдаа ярилцаж, зарим дасгал ажлуудыг хийх болно хэмээн хэлээрэй.</p> <p>Дараах сэтгэл зүйн үнэлгээнүүдийг хүүхдийн онцлог, нөхцөлд тохируулан бүгдийг нь эсвэл сонголтоор ажиллуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Хүүхдийн сэтгэл түгшилтийг тодорхойлох</b> Темпл Дорки нарын аргачлал. Хүүхдийн сэтгэл түгшилтийг зурган карт ашиглаж, ярилцах байдлаар тодорхойлдог аргачлал. Аргачлал нь нийт 28 зурагтай бөгөөд эрэгтэй хүүхдэд зориулсан 14 зураг, эмэгтэй хүүхдэд зориулсан 14 зургаас бүрдэнэ. Зураг бүр дээрх хүүхдийн царай хоосон бөгөөд зургийн доорх 2 төрлийн сэтгэл хөдлөл илэрхийлсэн царайнаас хүүхэд, сэтгэл зүйчтэйгээ ярилцах байдлаар сонголтоо хийнэ. /Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа болон зурган картыг Хавсралт 2. Сэтгэл зүйн үнэлгээний хуудсанд оруулав./</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэдтэй ярилцахдаа “яагаад?” гэх асуулыг асуухгүй байхыг хичээгээрэй. “Яагаад” гэж асуух үед өөрийг нь буруутгаж буй мэт санагдах, өөртөө итгэлгүй, өөрийн үнэлэмж доогуур үйлчлүүлэгчийн хувьд өөрийгөө буруутгах гэх мэтээр харилцаанд хаалт үүсэх эрсдэлтэй. Хэрэв учир шалтгааны асуух бол “Ямар учраас” гэх үгээр асууж болно.</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>- <b>Гар тест.</b> Энэхүү тест нь хүүхдийн айдас түгшилт, түрэмгийлэл, харилцааны хэрэгцээ зэрэг сэтгэл хөдлөлийн болон харилцааны онцлогийг илрүүлэх зорилготой. Тест нь гарын хөдөлгөөнийг илэрхийлсэн арван зураг бүхий картаас бүтнэ. /Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа болон зурган картыг Хавсралт 2. Сэтгэл зүйн үнэлгээний хуудсанд оруулав./</li> <li>- <b>Дуусгаагүй өгүүлбэрийн арга.</b> Хүүхдийн хандлагыг үнэлэх аргачлал бөгөөд энэхүү аргачлал нь үйлчлүүлэгч өөрийн тухайн үеийн бодлоор өгүүлбэрийг дуусгах буюу цэгийн оронд байж болох үгнүүдийг сэтгэл зүйчтэй ярилцах байдлаар өгүүлбэрийг дуусгадаг. /Аргын дагуу ажиллах дуусгаагүй өгүүлбэрүүдийг Хавсралт 2. Сэтгэл зүйн үнэлгээний хуудсанд оруулав./</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мөн сэтгэл хөдлөлийг “эерэг, сөрөг” гэж ангилж асуух нь хүүхдэд “сайн, муу” гэж үнэлж буй мэт санагдаж болзошгүй. Иймээс таатай, тааламжгүй гэх байдлаар тухайн сэтгэл хөдлөлөөс үүсгэдэг мэдрэмж дээр тулгуурлан нэрлэж болно.</li> <li>- Дан ганц сэтгэл зүйн үнэлгээгээр тухайн үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн хохирол, сэтгэл хөдлөлийг тодорхойлох боломжгүй. Учир нь тухайн хүчирхийллийн онцлог, даван туулж буй түүх, хүчирхийлэл үргэлжилсэн хугацаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж үйлчлүүлэгч бүрд харилцан адилгүй цаг хугацаанд сэтгэл зүйд учирсан хохирол, түүний шинж тэмдэг илэрч, ажиглагддаг.</li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн сэтгэл түгшилтийг тодорхойлох Темпл, Дорки нарын аргачлал.</li> <li>- Сэтгэл хөдлөл, харилцааны онцлогийг судлах Гар тест</li> <li>- Дуусгаагүй өгүүлбэрийн арга</li> </ul>	

### АЛХАМ 3. Батжуулалт, дүгнэлт /10 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалт төгсгөл хэсэгт орсон болохыг үйлчлүүлэгчид мэдрүүлэх үүднээс өмнөх уулзалтуудын адил өнөөдрийн уулзалт ямар мэдрэмж төрүүлсэн болох тухай ярилцаарай. Мөн уулзалт дуусахад үлдсэн хугацааг сануулж болно.</li> <li>- Үйлчлүүлэгчид уулзалт бүрийн дараа гэрийн даалгавар өгөх тухай өмнө нь сануулсан билээ. Үйлчлүүлэгч хүүхдэд дараагийн уулзалт хүртэл сэтгэл хөдлөл, мэдрэмжээ ажиглаж, тэмдэглэх даалгаврыг дараах зааварчилгааны дагуу танилцуулж өгнө. <ul style="list-style-type: none"> <li>o Өдөр бүрийн төгсгөлд, унтахаас хэсэг хугацааны өмнө тухайн өдөр ямар сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй байсан тухайгаа бодоорой.</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дараагийн уулзалтын өдөр болоогүй байсан ч удаан хугацаанд тааламжгүй сэтгэл хөдлөл мэдрэгдэх, даван туулахад хэцүү байх, хэн нэгэнтэй ярилцахыг хүсвэл сэтгэл зүйчтэй уулзаж болохыг үйлчлүүлэгчид сануулаарай.</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>○ Өдөр бүр олон янзын сэтгэл хөдлөл, мэдрэмж бидэнд хамт байдаг. Нэг өдрийн тухай бодоход танд олон төрлийн мэдрэмж төрсөн мэт санагдаж магадгүй. Тэгвэл өдрийн дийлэнх хугацаанд тантай ямар мэдрэмж, сэтгэл хөдлөл хамт байсан гэдгийг бодож тухайн сэтгэл хөдлөлөө 1-10 хооронд тоогоор жишээрэй. Энэхүү тоогоо дараагийн уулзалт хүртэл тэмдэглээрэй. Уулзалтын эхэнд сэтгэл хөдлөл, мэдрэмжээ тоогоор илэрхийлэх тухай ярилцсаныг дахин сануулаарай.</li> <li>- Мөн үйлчлүүлэгч хүүхдэд ямар нэгэн зүйлийг тогтмол санаж, хийх нь төвөгтэй санагдаж магадгүй гэсэн хэдий ч хичээгээд хийх тухай урамшуулаарай.</li> </ul>	
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн сэтгэл түгшилтийг тодорхойлох Темпл, Дорки нарын аргачлал.</li> <li>- Сэтгэл хөдлөл, харилцааны онцлогийг судлах Гар тест</li> <li>- Дуусгаагүй өгүүлбэрийн арга</li> </ul>	

Хөтөлбөрийн дагуух хоёр дахь удаагийн уулзалт буюу сэтгэл зүйн үнэлгээ хийх уулзалтын явцад хийгдсэн үнэлгээгээр доорх зүйлс ажиглагдсан тохиолдолд үйлчлүүлэгч хүүхдэд урт хугацааны сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, нийгмийн ажилтантай хамтран холбон зуучилна.

### **Сэтгэл зүйн урт хугацааны тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай гэж үзэх үндэслэл:**

#### **Сэтгэл зүйн үнэлгээгээр:**

- ⦿ Түгшилт/түгшүүр өндөр
- ⦿ Түрэмгийлэл, айдас хүчтэй илэрсэн
- ⦿ Өөртөө болон бусдад сөрөг хандлага илэрсэн тохиолдолд

#### **Бие махбодын талаас:**

- ⦿ Хүчирхийллийн улмаас бие махбодод гэмтэл, шарх, сорви үлдсэн
- ⦿ Хумсаа мэрэх болон бусад төрлийн зан үйлийн өөрчлөлттэй байж болзошгүй
- ⦿ Үсээ зулгаах эмгэгтэй байж болзошгүй
- ⦿ Булчин татваганах эмгэгийн илрэлтэй
- ⦿ Хүүхдийн ам хатах, гарын алга хөлрөх зэргээр сэтгэл түгшилтийн шинжүүд илэрч байгаа зэрэг тохиолдлуудад холбон зуучилна.

## ГУРАВ. МЭДРЭМЖ ГАДАГШЛУУЛАХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө бэлтгэх зүйлс:

- Сэтгэл зүйн хөтөлбөрийн дагуу зургийн хэрэгсэл, буддаг ном, баримал зэргийг урьдчилан бэлдэх.
- Үйлчлүүлэгчид санал болгож болох гэрийн даалгаврын жагсаалтыг урьдчилан гаргасан байх.
- Сэтгэл зүйч өөрт болон үйлчлүүлэгч ашиглах гар самбар, зураг зурах бичгийн цаас зэргийг бэлтгэсэн байх.
- Уулзалтын явцад үйлчлүүлэгч барих, базах тоглоом, хэрэгслийг ил гаргах.
- Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./



### Уулзалтын зорилго:

- Үйлчлүүлэгчид мэдрэмж, сэтгэл хөдлөлөө таних, анзаарахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл хөдлөл биеийн холбоосыг сайжруулах буюу ажиглуулах зорилготой. Мөн сэтгэл хөдлөлөө илэрхийлж ярилцахад дэмжлэг үзүүлнэ.

### АЛХАМ 1. Сэргээн санах, харилцаа үүсгэх /15 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалтын эхэнд өмнөх уулзалтаас хойш болсон үйл явдал, түүнтэй хамааралтай мэдрэмжийн тухай ярилцаарай. Ярилцахдаа үйлчлүүлэгчийн гэрийн даалгаварт тэмдэглэсэн сэтгэл хөдлөл, мэдрэмжээ оноогоор илэрхийлсэн хуудсыг ашиглаж болно.</li> <li>- Өнгөрсөн хугацаан дахь мэдрэмжийг ярьсны дараа өөрийн мэдрэмжээ ажиглахад ямар санагдаж байгаа буюу бэрхшээлтэй байна уу? амархан байна уу? хугацаа зарцуулж байна уу? зэргийг ярилцаж үйлчлүүлэгч өөрийн сэтгэл хөдлөлтэй хэр холбоос үүсгэж байгааг ажиглаарай.</li> <li>- Хэрэв хүүхэд нээлттэй, ярилцахад таатай байгаа нь ажиглагдвал үйлчлүүлэгчээс өөрийн мэддэг сэтгэл хөдлөлүүдийг нэрлэхийг хүсээрэй. Мөн тухайн нэрлэсэн сэтгэл хөдлөл биед хэрхэн, хаана мэдрэгддэг тухай ярилцаж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүчирхийллийн даван туулагч хүүхэд сэтгэл хөдлөлөө ажиглаж, түүнийг анзаарах, холбоос үүсгэхэд бэрхшээлтэй болсон байдаг. Иймээс сэтгэл хөдлөлөө эергээр зохицуулах, тайвшрахад суралцахын өмнөх гол хэсэг бол өөрийн мэдрэмжээ таних, нэрлэх юм.</li> <li>- Хүүхэд сэтгэл хөдлөл биед хэрхэн мэдрэгдэж байгааг тайлбарлахад бэрхшээлтэй байгаа мэт ажиглагдвал уур, айдас, баяр хөөр гэх мэт хүчтэй мэдрэгддэг сэтгэл хөдлөлүүдээс жишээ аваарай. Ингэхдээ чи маш их баяр хөөртэй байсан үеэ санаж байна уу? Тухайн үед зүрх, гэдэс цээж, гар, хөл орчим чинь хэрхэн мэдрэгдэж байсан бэ? гэх мэтээр нэг бүрчлэн ажиглуулж, ярилцаж болно.</li> </ul>

### Хэрэглэгдэхүүн / Арга барил

- Өмнөх уулзалтуудад хөтөлсөн Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.

## АЛХАМ 2. Мэдрэмжээ зургаар илэрхийлэх /20 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Өнөөдрийн уулзалтаар юу хиймээр байгаа тухай ярилцаж зураг зурах, баримлын шавраар дүрс хийх, зураг будах зэрэг боломжит дүрслэх хэрэглэлийн зүйлсийг үйлчлүүлэгчид санал болгоорой. Үйлчлүүлэгчийн сонгосон зүйлийг ашиглаж хамтдаа ажиллаарай.</li> <li>- Хүүхэд зураг зурахаар шийдсэн ч зурахаас бэрхшээж, нээлттэй биш байгаа тохиолдолд сэтгэл зүйч сараачсан байдалтай зураг зурж, үйлчлүүлэгч хүсвэл сараачиж, заавал ойлгогдохгүй, утга учиртай, сайхан зурах албагүй бөгөөд зурж байгаадаа анхаарч, мөр гаргахад л болох тухай тайлбарлаарай.</li> <li>- Хэрэв зураг будуулахаар шийдвэл үйлчлүүлэгчийн насанд тохируулж ажиллагаа ихтэй, багатай аль зургийг санал болгохыг шийдээрэй.</li> <li>- Үйлчлүүлэгч сонгосон хэрэглэгдэхүүнээ ашиглаж дүрс бүтээх, зурах, будах явцад тухайн хэрэглэгдэхүүн гарт хэрхэн мэдрэгдэж, хүрэхэд ямар санагдаж байгаа болон тухайн зүйлсийн шинж чанар, хэлбэр дүрсийн тухай ярилцаарай. Энэ нь үйлчлүүлэгч хүүхэд мэдрэмжээ илэрхийлэх явцдаа бие махбодоо анзаарах, холбоосоо сайжруулах эерэг нөлөөтэй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээний туршид үйлчлүүлэгчид сонголт өгөх нь үйлчлүүлэгчийг өөртөө итгэлтэй болгох, өөрийгөө таньж мэдэх, анзаарах боломжийг олгохоос гадна сэтгэл зүйчээс хамааралтай болохоос сэргийлэх, сэтгэл зүйн үйлчилгээ дууссан тохиолдолд үр дүнг хадгалахад эерэг нөлөөтэй.</li> <li>- Хугацаа хэсэгт дундаж цагийг оруулсан. Гэвч хүүхэдтэй ажиллахад цагт баригдах шаардлагагүй бөгөөд үйлчлүүлэгч тухайн бүтээлээ дуусгах хүртэл хугацаа олгоорой.</li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийн дагуух хэрэглэгдэхүүний багцад багтсан зургийн хэрэгсэл, буддаг ном, баримал зэргийг бэлтгэх.</li> </ul>	

## АЛХАМ 3. Батжуулалт, дүгнэлт /10 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалтын явцад хийсэн зураг, бүтээлийн тухай ярилцаж, сэтгэл зүйч тухайн бүтээлийн тухай өөрийн мэдрэмжээ хэлж, хүүхдийг урамшуулаарай.</li> <li>- Үйлчлүүлэгч хүүхдийг хийх дуртай зүйл буюу хобби, хийхэд таатай мэдрэмж төрдөг зүйлийн тухай ярилцаарай. Хийх дуртай зүйлтэй дүйцэх зүйлийг гэрийн даалгаварт өгөх буюу хийхэд хэр цаг хугацаа зарцуулахаас шалтгаалж даалгавар хийх давтамжийг хэлээрэй. Даалгаврын жишээнүүдийг дурдсан болно:</li> </ul>	<p>Үйлчлүүлэгч эдгээр зурах, будах, наах, атгах зэргээр үйлдэл хийх нь гарын жижиг булчинг идэвхтэй ажиллуулж түгшүүрийн мэдрэмжээ бууруулж тайвшрах, сэтгэл хөдлөл мэдрэмжээ гадагшлуулах, одоо цагт төвлөрөх боломжийг олгодог тул зөвлөгөөний үйл ажиллагааг дэмжих онцгой ач холбогдолтой. Иймд эдгээр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран бүтээгээрэй.</p>



<ul style="list-style-type: none"> <li>○ Өдөр бүрийн төгсгөлд, унтахаас хэсэг хугацааны өмнө тухайн өдөр ямар сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй байсан тухайгаа бодоорой. Хөдөлгөөн хийх дуртай бол Өглөө бүр хөнгөн дасгал хийх, гүйх, хүссэнээрээ бүжиглэх гэх мэт</li> <li>○ Өдөр бүрийн төгсгөлд, унтахаас хэсэг хугацааны өмнө тухайн өдөр ямар сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй байсан тухайгаа бодоорой. Зурах, бүтээл хийх дуртай бол зураг зурах, өнгийн цаас, шавраар бүтээл хийх гэх мэт</li> <li>○ Өдөр бүрийн төгсгөлд, унтахаас хэсэг хугацааны өмнө тухайн өдөр ямар сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй байсан тухайгаа бодоорой. Оёх дуртай бол даавуу холбож оёх, даавуун дээр оёдол хийх гэх мэт сэтгэл зүйч, үйлчлүүлэгч хамтран бүтээлч байдлаар хийх гэрийн даалгаврыг ярилцаж, сонгоорой.</li> </ul>	
<p><b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b></p>	
<p>- Сэтгэл зүйч өмнөх уулзалтуудын туршид үйлчлүүлэгчээс ажигласан онцлог шинж чанарт тохирох даалгаврын санааг урьдчилан жагсаасан байх.</p>	

## ДӨРӨВ. СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ХАРИУ ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ ЯРИЛЦАХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө бэлтгэх зүйлс:

- Сэтгэл зүйн хөтөлбөрийн дагуу үйлчлүүлэгчтэй ажиллах явцад үйлчлүүлэгчид гарсан эерэг үр дүн, түүний гаргасан зүтгэл, чармайлт, ахиц, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, ярилцах, зохицуулах чадвар зэргийн тухай бодож үйлчлүүлэгчийг урамшуулах, дэмжихэд бэлдсэн байх.
- Сэтгэл зүйн хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэхүүний багцад байх сэтгэл хөдлөлийн “Банхар” карт
- Уулзалтын явцад үйлчлүүлэгч барих, базах тоглоом, хэрэгслийг ил гаргах.
- Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./



### Уулзалтын зорилго:

- Үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлөө зохицуулах эерэг арга, зан үйлийг олж мэдэж, түүнийг батжуулах.

### АЛХАМ 1. Сэргээн санах, харилцаа үүсгэх /10 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалтын эхэнд өмнөх уулзалтаас хойш болсон үйл явдал, түүнтэй хамааралтай мэдрэмжийн тухай ярилцаарай. Мөн гэрийн даалгаврын тухай ярилцаж, үйлчлүүлэгч гэрийн даалгаврыг хийсэн бол урамшуулна. Хийгээгүй тохиолдолд буруутгахгүйгээр, дараагийн удаа хийх буюу энэ нь өөрт урт хугацаанд таатай мэдрэмж төрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндээ тордож байгаа талаар тухайн насны хүүхдэд тохирсон энгийн үгээр тайлбарлаарай.</li> <li>- Эхний уулзалтын төгсгөлд заасан амьсгалын дасгалыг сэргээж хамтдаа хийгээрэй. Мөн амьсгалын дасгал хийсний дараа биед ямар мэдрэмж төрж байгаа тухай ярилцаарай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Амьсгалын дасгал хийхэд цээж орчим хөндүүрлэж, булчинд таагүй мэдрэмж төрж байвал дасгалыг зогсоогоорой. Урт хугацаанд тааламжгүй мэдрэмжтэй, булчингийн чангаралтай байсан тохиолдолд хэвийн амьсгалах нь биед таагүй мэдрэмж төрүүлж болзошгүй.</li> </ul>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> <li>- Өмнөх уулзалтуудад хөтөлсөн Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.</li> <li>- Эхний уулзалтын зааварчилгаа хэсэг дэх амьсгалын дасгал</li> </ul>	

## АЛХАМ 2. Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн тухай ярилцах /20 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Өмнөх уулзалтуудаар сэтгэл хөдлөл, мэдрэмжийн тухай ярилцсан тул карт ашиглаж дэлгэрүүлж ярилцахад хүүхдэд саадгүй байх болно.</p> <p>Уулзалтын энэ хэсэгт сэтгэл хөдлөлийн картыг ашиглаж түгээмэл сэтгэл хөдлөлүүдийг мэдрэх үед хүүхэд хэрхэн илэрхийлж, даван туулж, зохицуулдаг болохыг ярилцана. Ингэхдээ дараах алхмуудын дагуу ажиллаарай:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ширээн дээр сэтгэл хөдлөлийн “Банхар” картын зургуудыг дээш харуулж өрнө. Үйлчлүүлэгч хүүхэдтэй хамт өрөхийг санал болгоорой. Өрөх явцдаа картыг тайлбарлана. “Энэхүү картад хүн бүрд мэдрэгддэг сэтгэл хөдлөлүүдийг мэдэрч, түүнийгээ нүүр царай, биеэрээ илэрхийлж байгаа нохойнуудын зургийг харуулсан. Өнөөдөр хоёулаа нохойнуудын илэрхийлж байгаа сэтгэл хөдлөлийн тухай ярилцана.”</li> <li>- Үйлчлүүлэгч хүүхдийн нэрлэж чадах сэтгэл хөдлөлүүдийг асуугаарай. Хүүхдүүд ихэвчлэн үндсэн сэтгэл хөдлөл болох уур, айдас, баяр хөөр, уйтгар гуниг зэргийг нэрлэж, илэрхийлэх картыг сонгодог. Өөрийн мэддэг сэтгэл хөдлөлүүдтэй дүйцэх зургийг олж, сонгохыг хүсээрэй. Сэтгэл зүйч хүүхдийн сонгосноос бусад картыг хураана.</li> <li>- Сонгосон карт бүрийг нэг нэгээр нь шинжилж, нээлттэй асуулт асуух байдлаар ярилцана. Энэ үед нохойд хэрхэн мэдрэгдэж байгаа, нохой энэхүү мэдрэмжээ яаж илэрхийлэх тухай, яавал энэ мэдрэмж алга болох, “жигжэрэх” тухай ярилцаарай. Хэрэв таагүй мэдрэмж бол нохой юу хийвэл энэ мэдрэмж таатай болж солигдох тухай асуугаарай. Таатай мэдрэмж бол юу хийвэл удаан хамт байх тухай ярилцаарай.</li> <li>- Ярилцах явцад үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлөө хэрхэн мэдэрч, илэрхийлдэг, зохицуулдаг болох тухай ажиглагдах болно. Үйлчлүүлэгч бүрд сэтгэл хөдлөлөө эергээр зохицуулдаг арга байдаг. Үүнийг олж, үйлчлүүлэгчийн урамшуулах, тухайн аргын тухай дэлгэрүүлж ярилцах замаар үйлчлүүлэгчийн үйлдлийг дэмжиж, батжуулаарай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл хөдлөлийн тухай ойлголт бага хүүхдийн хувьд өөрийн мэддэг сэтгэл хөдлөлийг нэрлэхдээ уйлах, инээх гэх мэт үйлдэл нэрлэх нь түгээмэл байдаг. Энэ тохиолдолд сэтгэл зүйч чи ямар мэдрэмж төрсөн үедээ уйлдаг вэ, инээдэг вэ гэх мэтээ мэдрэмж рүү чиглүүлэх асуултыг асуугаарай.</li> <li>- Сэтгэл хөдлөлийн картыг олон төрлөөр ашиглаж болно. Иймээс зааварчилгаанд дурдсан байдлаас гадна бүтээлчээр сэтгэж ашиглаарай. <ul style="list-style-type: none"> <li>o Одоогийн сэтгэл хөдлөлтэй дүйх картыг сонгох.</li> <li>o Өнгөрсөн 7-10 хоногт мэдрэгдсэн сэтгэл хөдлөлийг сонгох. Мөн үйл явдлаас юу мэдэрсэн тухай ярилцахдаа ашиглах</li> <li>o Гэр бүлийн тухай ярилцахдаа гэр бүлийн гишүүдээс мэдэрдэг сэтгэл хөдлөлийг картаар илэрхийлэх.</li> <li>o Түүх, үлгэр зохиох.</li> <li>o Сэтгэл хөдлөл илэрхийлсэн картыг дуурайлган зурах гэх мэт.</li> </ul> </li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл хөдлөлийн “Банхар” карт</li> </ul>	

### АЛХАМ 3. Батжуулалт, дүгнэлт /10 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн уулзалт тул сэтгэл зүйн үйлчилгээний явцад суралцсан зүйл, үр дүн зэргийг ярилцаж, үйлчлүүлэгчид гарсан эерэг үр дүн, ахиц зэргийг дурдаж урамшуулаарай. Хүүхдэд үгээр илэрхийлэх нь бэрхшээлтэй байж магадгүй. Энэ тохиолдолд сэтгэл зүйч үр дүнг дурдах байдлаар санаачилгатай оролцоорой.</li> <li>- Цаашид өөрийн сэтгэл хөдлөлийг хэрхэн анзаарах тухай дүгнэн ярилцаж, өмнөх хэсэгт сэтгэл зүйч олж мэдсэн сэтгэл хөдлөлөө эергээр зохицуулах аргыг ашиглах тухай сануулаарай. Мөн өөрийн дуртай, таатай санагддаг зүйлсээ хийх боломж, цагийг гаргаж байх тухай санал болгоорой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчийг урамшуулах-даа үнэн бодит нөхцөл байдал тулгуурлах ёстой. Иймээс сэтгэл зүйч урьдчилан уулзалтад бэлтгэх нь чухал.</li> <li>- Сэтгэл зүйн үйлчилгээ болон хамгаалах байрнаас гарах болсон хэдий ч дахин аюулгүй байдлын хамгаалалт шаардлагатай тохиолдолд хамгаалах байр нээлттэй байх тухай тайлбарлаж болно.</li> </ul>

## СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮЕД ТУЛГАРЧ БОЛОХ БЭРХШЭЭЛ, ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИ

Тулгарч болзошгүй бэрхшээл	Даван туулах стратеги
<p><i>Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай нь ажиглагдаж байгаа хэдий ч үйлчлүүлэгч сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдахыг хүсэхгүй байгаа тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээний зорилго, ач холбогдол, үр дүнг нас, сэтгэхүйн онцлогт нь тохиромжтой байдлаар тайлбарлаж өгнө. Хэрэв үйлчлүүлэгч өмнөх сэтгэл зүйн үйлчилгээнээс шалтгаалж мэргэжилтэнд итгэх итгэл буурсан бол үйлчилгээнд баримтлах хил хязгаар, ёс зүйн хэм хэмжээг тайлбарлаарай. Сэтгэл зүйч үйлчилгээг хангалттай тайлбарлаж чадсан хэмээн үзвэл үйлчлүүлэгчид шийдвэр гаргах боломжийг олгоорой.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчид үр дүнг тайлбарлахдаа амлалт өгөхөөс зайлсхийгээрэй. Үүний оронд үйлчилгээний явцад ямар эерэг үр дүнд чиглэх, үүний тулд хэрхэн хамтран ажиллах тухай тайлбарлаарай.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчийн үг, үйлдэлд огт хариу үйлдэл үзүүлэхгүй байвал яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал, харилцааны онцлог, сэтгэл зүйн цочрол, түүний илрэл зэрэг олон зүйлсээс хамаарч зан үйл, хариу үйлдэл шалтгаална. Иймээс үйлчлүүлэгчийн чимээгүй байх, сэтгэл зүйчид харилцан үйлдэл үзүүлэхгүй байх нь үйлчилгээг хүсэхгүй байна гэсэн илэрхийлэмж болохгүй. Иймээс сэтгэл зүйч өөр өөр арга техникийг үйлчлүүлэгчид санал болгож, хэт тулгаж, яарахгүйгээр үйлчилгээг үргэлжлүүлээрэй. Зарим үед үйлчлүүлэгчтэй хамт чимээгүй суух, ямар нэгэн зүйлсийг ажиглах, зураг зурах, сараачих зэргээр идэвхтэй биш аргуудыг ашиглаарай.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчийн идэвхгүй байдлыг үйлчилгээнээс татгалзаж байна хэмээн дүгнэлт хийж, үйлчилгээг зогсоож болохгүй бөгөөд хариу үйлдэл бүр ялгаатай байж болно гэдгийг санаарай.</p>
<p><i>Үйлчилгээнд ашиглаж буй арга техник үйлчлүүлэгчид таагүй мэдрэмж төрүүлж байгаа тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчилгээнд ашиглаж буй арга, аргачлалын явцад болон дараа үйлчлүүлэгчид ямар санагдсан тухай асууна. Хэрэв түүний бие махбодод таагүй мэдрэмж төрүүлсэн, тааламжгүй бодлыг үүсгэсэн бол тухайн мэдрэмж, сэтгэл хөдлөлийн тухай дэлгэрүүлж ярилцах, тухайн мөчид болон одоод хэрхэн мэдрэгдэж байгаа тухай асуугаарай.</p> <p><b>Анхаар:</b> Зарим дасгал ажлыг хийх үед үйлчлүүлэгчийн сэтгэцийн гэмтэл сэдэрч болзошгүй тул юу сэдэрэж байна гэдгийг ажиглаж дахин давтагдахаас зайлсхийгээрэй. Мөн үйлчлүүлэгчийн сэтгэцийн гэмтлийг сэдэрэж болзошгүй зүйлс, нөхцөл, сэдэрэх мөчид хэрхэн өөрийгөө тайвшруулах тухай сэтгэл зүйн боловсрол олгоно.</p>

<p><i>Амьсгалын дасгал хийлгэх үед үйлчлүүлэгч бие махбод, мэдрэмжээ ажиглахгүй байвал яах вэ?</i></p>	<p>Амьсгал, биеийн мэдрэмжийг хослуулан ажиглах урт хугацааны дасгал хийлгэхээс зайлсхийгээрэй. Үүний оронд зөвхөн амьсгалд төвлөрөх дасгал хийлгэж болно. Боломжит дасгалын жишээг доор оруулав:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бичгийн цаасыг 8-10 см урттай, 2 см өргөнтэй хайчилна. Цаасны нэг үзүүрээс чимхэж хамрын доор барина. Амьсгал авах болон гаргах үед цаас хэрхэн хөдөлж байгааг ажиглаж амьсгалын дасгал хийнэ.</li> <li>- Жижиг хэмжээтэй нимгэн цаасан уут эсвэл зөөлөн гялгар торыг амандаа барьж амьсгал авах, гаргах үйлдлийг хийнэ.</li> </ul> <p><b>Анхаар:</b> Урт хугацааны тааламжгүй мэдрэмж, хямрал эсвэл гэнэтийн цочролоос шалтгаалж үйлчлүүлэгч өөрийн биеийн мэдрэмжийг ажиглахгүй байх нь хэвийн хариу үйлдэл. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчийг тайвшруулж, аажмаар биеийн мэдрэмжийг ажиглуулахад чиглүүлнэ.</p>
<p><i>Сэтгэл зүйн зөвлөгөөний дараах гэрийн даалгаврыг үйлчлүүлэгч удаа дараа хийхгүй байгаа тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Тодорхой үйлдлийг тогтмол хийхээс зайлсхийх, хойшлуулах зэрэг нь үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал, хүчирхийллийн үед үзүүлэх сэтгэл зүйн хохирлоос шалтгаалсан түүний хариу үйлдэл болох тухай сэтгэл зүйн боловсрол олгоно. Мөн сэтгэл зүйн үйлчилгээний зорилго, зорьж буй үр дүнд хэрхэн хүрч болох тухай үйлчлүүлэгчид ойлголт төрүүлэх үүднээс сэтгэл зүйч болон үйлчлүүлэгч юу хийж чадах тухай хамтдаа төлөвлөж болно.</p> <p><b>Анхаар:</b> Гэрийн даалгаврыг хийгээгүйгээс шалтгаалж түүнийг буруутгах, зэмлэх байдлаар харилцахгүй байх. Үүний оронд даалгавар хийх тухай бодох, тогтмол хийх нь хүнд санагдаж байгааг ойлгож байгааг илэрхийлээрэй.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчид итгэхгүй байх тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчийн туулсан туршлагаас шалтгаалж харилцаанд итгэл алдрах, аюултай байдлыг мэдрэх нь хэвийн хариу үйлдэл. Иймээс мэргэжилтэнд итгэх итгэл үүсэх нь урт хугацаа шаардах тул түүнд аюулгүй байдлыг мэдрэх боломжтой орчин, харилцааг бий болгож сонголтыг өгч үйлчилгээг үргэлжлүүлнэ.</p> <p><b>Анхаар:</b> Хүчирхийллийн даван туулагчийн сэтгэл зүйн онцлогийг урьдчилан судалснаар үйлчилгээг төлөвлөх, бэлэн байхад хялбар болно.</p>
<p><i>Хөтөлбөрт дурдсан арга техникийг ашиглах, сэтгэл зүйн үнэлгээг хийлгэхээс татгалзсан тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Хэрэв үйлчлүүлэгч сэтгэл зүйчийн санал болгосон арга техникийг ашиглахаас татгалзсан тохиолдолд түүнд боломжит сонголтуудыг олгож, нээлттэй асуух байдлаар үйлчилгээг үргэлжлүүлнэ.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчид тулгах, үүнээс өөр арга байхгүй мэт шаардах зэрэг нь сэтгэл зүйчид итгэх итгэлийг бууруулдаг. Хэрэв сэтгэл зүйчид өөр санал болгох арга техник байхгүй бол үйлчлүүлэгчид үнэн байдлаа хэлж дараагийн уулзалт дээр бэлтгэлтэй байхын тулд юу хийхийг хүсэж байгааг нь асууж ярилцана.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчид хэт дасах, хамааралтай байдал ажиглагдсан тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Нэг талаар сэтгэл зүйч үйлчилгээ үзүүлэхдээ ёс зүйн зарчим дахь хил хязгаарыг хангалттай баримтлаагүй тохиолдолд, нөгөө талаар хүчирхийллийн даван туулагчийн сэтгэл зүйн онцлогоос шалтгаалж сэтгэл зүйчид дасах байдал ажиглагдаж болно. Энэ тохиолдолд сэтгэл зүйч үйлчилгээнд хил хязгаарыг баримталж, хувийн харилцаа биш мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгааг үйлчлүүлэгчийн насны онцлогт тохирсон байдлаар ойлгуулна. Мөн уулзалт бүрийн дараа даалгавар өгөх, уулзалтын хугацааг тогтмолжуулах, сэтгэл зүйчгүйгээр сэтгэл зүйн асуудлаа даван туулах дадлыг бэхжүүлэхийг хичээнэ.</p>

## УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУУДАС

### 1. Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл

Үйлчлүүлэгчийн код:	_____
Нас, хүйс:	_____, _____
Даван туулж буй хүчирхийллийн төрөл:	- Гэр бүлийн хүчирхийлэл - Бэлгийн хүчирхийлэл - Хүүхдийн эсрэг хүчирхийлэл Бусад _____

### 2. Үе шат, уулзалтын тэмдэглэл

№	Арга, техник	Тэмдэглэгээ	Тайлбар
Уулзалтын үе шат: Код 2-1		Огноо: _____ / ____ / ____	
1	Элсэн заслын үеийн зан байдал		
2	Амьсгалын дасгал хийлгэсэн эсэх	- Тийм - Үгүй	
Уулзалтын үе шат: Код 2-2		Огноо: _____ / ____ / ____	
1	Мэдрэмжээ оноогоор илэрхийлэх арга зааж өгсөн эсэх	- Тийм - Үгүй	
2	Сэтгэл түгшилтийн оноо /хувь/ түвшин		
3	Гар тестийн үзүүлэлтүүд	Agg – F – Aff – Dep – Com – Ten –	
4	Хүүхдийн хандлага	- Эерэг - Сөрөг - Саармаг	
Уулзалтын үе шат: Код 2-3		Огноо: _____ / ____ / ____	
1	Хүүхдээр зуруулсан зургийн тэмдэглэл		
2	Хүүхдийн зан байдлын талаар анзаарагдсан зүйлс		
Уулзалтын үе шат: Код 2-4		Огноо: _____ / ____ / ____	
1	Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн талаар тэмдэглэл		

### 3. Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ТҮГШИЛТИЙГ БУУРУУЛАХ СЭТГЭЛ ЗҮЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүчирхийллээс шалтгаалж үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт		
Бие махбодод гарсан өөрчлөлт	Сэтгэл зүйд гарсан өөрчлөлт	Зан үйлд гарсан өөрчлөлт
Үйлчлүүлэгчид гарсан сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн		
Бие махбод, сэтгэл зүй, зан үйлд гарсан эерэг үр дүн	Сэтгэл зүйн үйлчилгээний явцад суралцсан чадвар, итгэл үнэмшил, ахиц	Мэргэжилтний дүгнэлт болон үйлчлүүлэгчийн сэтгэгдэл



## СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

(Үйлчлүүлэгчид зориулсан)


### 1. Хүүхдийн сэтгэл санааны байдлыг тодорхойлох Темпл, Дорки нарын аргачлал

**Зааварчилгаа:** Зургуудыг дарааллаар нь хараарай. Энэ зураг дээр ямар үйл явдал болж байгаа мэт харагдаж байна вэ? Чиний бодлоор зураг дээрх хүүхэд юу хийж байна вэ?

- Хүүхдийн царай таатай байна уу, таагүй мэдрэмжтэй байх шиг харагдаж байна уу? Ямар учраас хүүхэд ийм мэдрэмжтэй байна гэж чи бодож байна вэ?

**Темпл, Дорки нарын аргачлалын зурган карт** (Охидод зориулсан хувилбар)


1



2




3




4




5



6




7




10

8




11

9




12





13




14




1



2




3




4




5





6





7





8





9




10




11




12



13




14




## 2. “Гар тест”.

**Зааварчилгаа:** Гарын хөдөлгөөн бүхий 10 зураг үзүүлнэ. “Таны/чиний бодлоор зураг дээрх гарын эзэн юу хийж байгаа вэ?, Энэхүү гарын эзэн юу хийж болох вэ? Та/чи өөрийн төсөөлж буй бүх хувилбарыг нэрлээрэй” Харин 10-р зургийн тухайд “Та/чи ямар нэг гарыг төсөөл. Тэр гараар хийж болох бүх үйлдлийг хэлээрэй.


**“Гар тест”-ийн зургууд:**




I



II




III



IV



V




VI



VII



VIII



IX

X

### 3. Дуусгаагүй өгүүлбэр

**Зааварчилгаа:** Дараах өгүүлбэрүүдийг санаандаа орж буйгаар гүйцээж хэлж эсвэл бичиж болно.

1. Миний бодоход манай аав хааяа \_\_\_\_\_.
2. Хэрвээ бүгд миний эсрэг байвал би \_\_\_\_\_.
3. Тэнэг гэдгийг мэдэж байгаа ч би \_\_\_\_\_ айдаг.
4. Жинхэнэ найз бол \_\_\_\_\_.
5. Бусад гэр бүлтэй харьцуулахад манай гэр бүл \_\_\_\_\_.
6. Ээж бид хоёр \_\_\_\_\_.
7. Хэрвээ манай аав \_\_\_\_\_.
8. Би \_\_\_\_\_ болохоор өөрийгөө том болсон гэж бодож байна.
9. Манай ангийнхан намайг \_\_\_\_\_-с айдаг гэдгийг мэдэхгүй.
10. \_\_\_\_\_ хүүхдүүдэд дургүй.
11. Манай гэрийнхэн надтай яг л \_\_\_\_\_ шиг харьцдаг.
12. Миний ээж \_\_\_\_\_.
13. Аавыгаа \_\_\_\_\_ байгаасай гэж би хүсдэг.
14. Надад миний \_\_\_\_\_ нь таалагддаггүй.
15. Би айхаа болихыг хүсдэг ч \_\_\_\_\_.
16. \_\_\_\_\_ хүүхдүүдэд дуртай.
17. Миний мэдэх ихэнх гэр бүл \_\_\_\_\_.
18. Бүх ээжүүдийг \_\_\_\_\_ гэж би боддог.
19. Миний аав \_\_\_\_\_ гэж би боддог.
20. Би бүтэлгүйтэхээрээ \_\_\_\_\_.
21. Надад аймшигтай санагдвал би \_\_\_\_\_.
22. Намайг байхгүй хойгуур миний найз нар \_\_\_\_\_.
23. Намайг бага байхад манай гэрийнхэн \_\_\_\_\_.
24. Би ээждээ хайртай ч \_\_\_\_\_.

## СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

(Сэтгэл зүйчид зориулсан)

### 1. Хүүхдийн сэтгэл түгшилтийг тодорхойлох Темпл, Дорки нарын аргачлал

**Зорилго:** Хүүхдийн сэтгэл түгшилтийн түвшинг тодорхойлоход чиглэнэ.

**Онцлог:** Охид ба хөвгүүдэд зориулсан хувилбартай. Энгийн, хялбар даалгавруудаас бүрдэнэ.

**Бэлтгэл:** Хүүхдэд харуулах зурган хэрэглэгдэхүүн

**Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа:** Хүүхдэд зургуудыг дарааллаар нь харуулна. Энэ зураг дээр ямар үйл явдал болж байгаа мэт харагдаж байна вэ? Чиний бодлоор зураг дээрх хүүхэд юу хийж байна вэ?

- Хүүхдийн царай таатай байна уу, таагүй мэдрэмжтэй байх шиг харагдаж байна уу? Ямар учраас хүүхэд ийм мэдрэмжтэй байна гэж чи бодож байна вэ? хэмээн аль болох тулгасан биш, нээлттэй асуултыг асууж ярилцана.
- Ярилцах явцдаа сэтгэл зүйч үйлчлүүлэгчийн сонгож байгаа царайг, тайлбарын хамт тэмдэглэж авна.

**Үр дүнг боловсруулах:** Хүүхэд 14 зургаас тааламжгүй сэтгэл хөдлөлтэй царайг сонгосон хувийг тооцож гаргана. Үйлчлүүлэгч хүүхдийн сэтгэл түгшилт, түгшүүрийн хувийг уулзалтын тэмдэглэл дээр бүртгэнэ.

Тааламжгүй сэтгэл хөдлөлтэй царайг сонгосон зургийн хувь	Түгшүүрийн түвшин
50%-с дээш тааламжгүй сэтгэл хөдлөлтэй царайг сонгосон	Түгшүүр өндөр
20%-49% хооронд тааламжгүй сэтгэл хөдлөлтэй царайг сонгосон	Түгшүүр дунд зэрэг
19%-с доош тааламжгүй сэтгэл хөдлөлтэй царайг сонгосон	Түгшүүр бага

### Үр дүнг сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглах:

Хүүхэд түгшүүр өндөртэй байх үед эцэг эх, асран хамгаалагчидтай хүмүүжлийн эерэг аргуудын талаар ярилцах, цаашид сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамруулах нь зүйтэй талаар мэдээлэл өгнө.

### 2. Сэтгэл хөдлөл, харилцааны онцлогийг илрүүлэх “Гар тест”.

**Зорилго:** Сэтгэл түгшилт айдас, түрэмгий байдлын илрэл зэрэг сэтгэл хөдлөл болон харилцааны онцлогийг илрүүлнэ.

**Онцлог:** Гар тестэд ашиглах зурган картуудыг хүүхдэд харуулж, ярилцах байдлаар явагдах тусгалын арга. Сэтгэл зүйн онцлогийг нарийн илрүүлэх боломжтой.

**Бэлтгэл:** Гарын зургууд, хариултын хуудас

**Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа:** Гарын хөдөлгөөн бүхий 10 зургийг үйлчлүүлэгч хүүхдэд нэг



нэгээр нь харуулж ярилцана. Ярилцахдаа “Таны бодлоор зураг дээрх гарын эзэн юу хийж байгаа вэ? хэмээн асууна. Хэрэв судалгаанд оролцогчид заавар ойлгомжгүй бол зааврыг хялбарчилж “Энэхүү гарын эзэн юу хийж болох вэ? Та өөрийн төсөөлж буй бүх хувилбарыг нэрлэнэ үү?” гэж асууна. Харин 10-р зургийн тухайд “Та ямар нэг гарыг төсөөл. Тэр гараар хийж болох бүх үйлдлийг хэлнэ үү?” гэсэн заавар өгнө.

Үйлчлүүлэгчийн бүх хариултыг хүлээн авах ба судалгаанд оролцогчийн ойлгомжгүй, хоёрдмол утгатай хариултын хувьд нэмэлт тайлбар авч болно. Нэг л төрлийн, өвөрмөц хариулт давтагдахаас сэргийлэх хэрэгтэй. Судалгаанд оролцогч судалгааны хуудсыг эргүүлж, тойруулан харахыг зөвшөөрнө. Нэг зургийг нэрлэхэд зарцуулсан хугацааг тэмдэглэж авч, хариулт болон хугацааг хариултыг хуудсан дээр тэмдэглэнэ. Хүүхэд удаан бодож хариулт өгч байна уу гэдэг нь сэтгэцийн үйл ажиллагааны хурдыг харуулахаас гадна болгоомжилж буй эсэхийг илэрхийлж болно.

**Үр дүнг боловсруулах алхам:**

**Алхам 1.** Нийт хариултын тоог гаргана.

**Алхам 2.** Хариултыг үнэлэх доорх үзүүлэлтүүдэд хамаарах хариултын тоог гаргана.

<b>Хариултыг үнэлэх үзүүлэлт</b>						
№	Тэмдэглэгээ	Утга	№	Тэмдэглэгээ	Утга	№
1.	(Agg)	Түрэмгийлэл	8. 5	(Crip)	Эрэмдэг байдал	
2.	(Aff)	Цухалдал	9.	(Ten)	Түгшүүр, хүчдэл	
3.	(Com)	Харилцаа	10.	(Ex)	Эксгибиционизм	
4.	(F)	Айдас	11.	(Fail)	Хариулж чадаагүй	

**Алхам 3.** Үзүүлэлт бүрд хамрагдах хариултын хувийг бодож гаргана.

**Үр дүнг сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглах:**

Хүүхдийн зан байдалд зонхилон илэрч буй хэвийн бус сэтгэл хөдлөл, тухайлбал айдас, түгшүүр, цухалдал, түрэмгий байдал нь хүүхдийн цаашдын төлөвшилд ямар эрсдэлтэй болох талаар эцэг эх, асран хамгаалагчид тайлбарлаж өгнө.

Хүүхэдтэй сэтгэл хөдлөлийн талаар ярилцахдаа тестийн үр дүнг ашиглана. Ялангуяа айдас түгшилт, түрэмгий байдал хэр илэрч байгааг харгалзан үзэх нь зүйтэй.

**Хариултын хуудас:**

№	ХАРИУЛТ
1	
2	
3	
4	
5	
6	

7	
8	
9	
10	

### 3. Дуусгаагүй өгүүлбэр

**Зорилго:** Хүүхдийн эцэг, эх, найз нөхөд, хүрээлэн буй орчин, нийгэмд хандах хандлагыг илрүүлнэ.

**Онцлог:** Үйлчлүүлэгч хэнээс, ямар орчин нөхцөлөөс тавгүй мэдрэмж авдаг болохыг судлахад тохиромжтой тусгалын арга юм. Сэтгэл зүйч өөрөө тэмдэглэх, эсвэл 8-10 насны хүүхдээр өөрөөр нь бичүүлж болно. Хүүхдийн нас болон ам бүлийн байдал зэргээс хамааран зарим асуултыг хэрэглэхгүй байж болно.

**Бэлтгэл:** Дуусгаагүй өгүүлбэрийн хариултын хуудас, үзэг

**Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа:** Дараах өгүүлбэрүүдийг санаандаа орж буйгаар гүйцээж хэлж эсвэл бичиж болно.

**Үр дүнг боловсруулах:** Үйлчлүүлэгчдийн Хариултын байдлаар 5 үнэлгээ өгнө.


- ⦿ Аз жаргалгүй, нөхөрсөг биш -2
- ⦿ Тийм ч нөхөрсөг бус, бухимдсан – 1
- ⦿ Саармаг ялгаагүй 0
- ⦿ Хэвийн +1
- ⦿ Маш нөхөрсөг, аз жаргалтай +2 (Сөрөг үнэлгээ нь хүүхдийн хувьд асуудалтай байгаа хандлагыг тодорхойлно.)

Хандлага	Өгүүлбэрийн дугаар	Хүүхдийн хариулт
Эцэгтээ хандах	1, 7, 13, 19	
Өөртөө хандах	2, 8, 14, 20	
Орчиндоо хандах	3, 9, 15, 21	
Найз нөхдөдөө хандах	4, 10, 17, 22	
Гэр бүлдээ хандах	5, 11, 17, 23	
Эхдээ хандах	6, 12, 18, 24	

### Үр дүнг сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглах:

Үйлчлүүлэгчийн тааламжгүй хандлагыг илрүүлснээр сэтгэл зүйн үйлчилгээ, ярилцлагыг хөтлөхөд нэмэлт мэдээлэл болно. Эцэг эхдээ таагүй хандлагатай бол хүүхдийн асуудлаар хэрхэн ярилцах, өөртөө итгэлгүй бол цаашид ямар арга хэмжээ авах, гэр бүлийн зүгээс юунд анхаарах зэргээр тусламж үйлчилгээг оновчтой төлөвлөх ач холбогдолтой.

## СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, МЭДРЭМЖЭЭ ОНООГООР ИЛЭРХИЙЛЭХ ШУГАМ



## ХӨТӨЛБӨРИЙГ ДАГАЛДАХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

<i>Арга, техник</i>	<i>Хэрэглэгдэхүүн</i>	<i>Хөтөлбөрийн аль үед ашиглагдах</i>
<b>Хамгаалах байран дахь нэгдсэн багц хэрэглэгдэхүүн</b>		
Элсэн заслын хэрэглэгдэхүүн	Элсэн заслын тавцан	НЭГ. Аюулгүй байдлын мэдрэмж бий болгох, тааламжгүй мэдрэмжийг бууруулах уулзалт
	Элсэн заслын тоглоом	
Хөгжим заслын хэрэглэгдэхүүн	Спикер	НЭГ. Тайвшруулах, нөхцөл байдлын түгшүүр багасгах уулзалт
	Memory card	
	Чихэвч	
Метафор картууд	Банхар карт Ий күү карт	ДӨРӨВ. Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн тухай ярилцах уулзалт
Тайвшруулах хэрэглэгдэхүүн	Банхар чихмэл	Бүх үед ашиглаж болно.
Оношилгооны хэрэглэгдэхүүн	Модон тоглоом	ХОЁР. Сэтгэл зүйн үнэлгээнд болон амраах зорилгоор аль ч үед ашиглахад тохиромжтой.
<b>Бага насны (3-10 нас) хүүхдэд зориулсан багц хэрэглэгдэхүүн</b>		
Тайвшруулах зурах, будах хэрэглэгдэхүүн	Тайвшруулах буддаг ном	ГУРАВ. Мэдрэмж гадагшлуулах уулзалт
	Зургийн дэвтэр	
	Өнгийн харандаа	
	Өнгийн цаас	Мөн хөтөлбөрийн бүхий л хэсэгт үйлчлүүлэгчид нээлттэй байдлаар санал болгоно.
	Цавуу	
	Ном	Хөтөлбөрт заасан арга техник үйлчлүүлэгчид тохиромжгүй байх тохиолдолд нээлттэй байдлаар санал болгоно.
Слайм		

## НОМ ЗҮЙ

1. Андреа Ж.Шески, Хейли Толл. Хүчирхийллээс түр хамгаалах байр. УБ.,2017
2. Б.Батсайхан, М.Дэлгэржав. Сэтгэл судлалын бага тайлбар толь. УБ.,2013
3. Н.Орёл, Д.Цогзолмаа. Эмгэг сэтгэл судлал, сэтгэц физиологийн зарим үндсэн шинжилгээг эмнэл зүйн практикт хэрэглэх арга зүй. УБ.,2006
4. Г.Сарантуяа. Сэтгэц оношилгоо. УБ.,2020
5. Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ. УБ.,2020
6. <https://www.facebook.com/100057669720777/videos/699762537432648>
7. <https://psycabi.net/testy/645-test-trevozhnosti-r-temml-m-dorki-v-amen-metodika-vyberi-nuzhnoe-lit-so-proektivnaya-diaagnostika-detej>